



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	<b>1</b>
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	<b>2-10</b>
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	<b>11-49</b>
<hr/>	
<i>1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/</i>	<b>11-43</b>
<i>2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	<b>44-49</b>
<i>3. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	<b>49-50</b>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 08 дугаар сарын  
20-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 80.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 44 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Батлут, Ц.Даваасүрэн, П.Мөнхтулга,  
Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг.

**Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэн/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын зөвлөх Р.Батгэрэл, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын дарга Л.Идэрцогт, Жижиг, дунд үйлдвэрийн газрын Бодлого зохицуулалтын газрын дарга А.Гэрэлзаяа, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ш.Цэнд-Аюуш, “Дарханы арьс ширний цогцолбор” төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Жамух нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Нандингэрэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, Д.Жаргалсайхан, Д.Батбаяр нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн хариулж, тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**С.Ганбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Эдийн засгийн бодлогын хүрээнд” хэрэгжүүлэх мега төслийн хүснэгтийн 13-т тусгагдсан төслийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 12  
Бүгд: 17  
29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар саналаа тайлбарлав.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Эдийн засгийн бодлогын хүрээнд” хэрэгжүүлэх мега төслийн хүснэгтийн 13-т тусгагдсан төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

13.Төслийн нэр: Алт цэвэршүүлэх үйлдвэр гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа саналаа тайлбарлав.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Эдийн засгийн бодлогын хүрээнд” хэрэгжүүлэх мега төслийн хүснэгтийн 10-т тусгагдсан төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.Төслийн нэр: “Монгол орны зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах, зэс болон бусад эрдэс, элементийг цэвэршүүлэх үйлдвэр байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17  
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар саналаа тайлбарлав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Ж.Золжаргал, Б.Тулга, Д.Жаргалсайхан, Б.Уянга нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**С.Ганбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**С.Ганбаатар:** 3.Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Эдийн засгийн бодлогын хүрээнд” хэрэгжүүлэх мега төслийн хүснэгтийн 10-т тусгагдсан төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.Төслийн нэр: “Монгол орны зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах, зэс болон бусад эрдэс, элементийг цэвэршүүлэх үйлдвэр байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 11  
Бүгд: 17  
35.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Эдийн засгийн бодлогын хүрээнд” хэрэгжүүлэх мега төслийн хүснэгтийн 10-т тусгагдсан төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.Төслийн нэр: Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах цогцолбор гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа саналаа тайлбарлав.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Эдийн засгийн бодлогын хүрээнд” хэрэгжүүлэх мега төслийн хүснэгтийн 9-т тусгагдсан төслийн “Хүрэх үр дүн” баганад доор дурдсанаар агуулгатай Хүрэх үр дүнг шинээр нэмэх:

9.Хүрэх үр дүн:-Нүүрс-химийн технологийг эзэмших, боловсон хүчнээ бэлтгэх, ирээдүйн томоохон төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулж, хий, түлш, нийлэг материал, устөрөгч гарган авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар саналаа тайлбарлав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Б.Уянга нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр нар хариулж, тайлбар хийв.

6.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Эдийн засгийн бодлогын хүрээнд” хэрэгжүүлэх мега төслийн хүснэгтийн 8-д тусгагдсан төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.Төслийн нэр: Уран олборлох, баяжуулах үйлдвэр гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 15

Бүгд: 17

11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа саналаа тайлбарлав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Л.Мөнхбаясгалан, Г.Очирбат нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх нар хариулж, тайлбар хийв.

7.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Эдийн засгийн бодлогын хүрээнд” хэрэгжүүлэх мега төслийн хүснэгтийн 9-д тусгагдсан төслийн “Хүрэх үр дүн” хүснэгтийн “Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг” гэсний өмнө “Нүүрс-химийн үйлдвэр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 13

Бүгд: 17

23.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа саналаа тайлбарлав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат нар хариулж, тайлбар хийв.

8.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Эдийн засгийн бодлогын хүрээнд” хэрэгжүүлэх мега төслийн хүснэгтийн 9-д тусгагдсан төслийн “Хүрэх үр дүн” хүснэгтийн “Нэмүү өртөг шингэсэн

хүнд үйлдвэрлэлийг” гэсний өмнө “Нүүрс-химийн үйлдвэр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 13  
Бүгд: 17  
23.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа саналаа тайлбарлав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат нар хариулж, тайлбар хийв.

9.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “Эдийн засгийн бодлогын хүрээнд” хэрэгжүүлэх мега төслийн хүснэгтийн 11-д тусгагдсан төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

10.Төслийн нэр: Гангийн цогцолбор гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа саналаа тайлбарлав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат хариулж, тайлбар хийв.

10.Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.2.Боомтын шинэчлэл, тээвэр логистик” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.2.20 дахь дэд заалт нэмж, үүнтэй холбогдуулан дугаарыг өөрчлөх:

“3.3.2.20.Даянгийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл саналаа тайлбарлав.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга тайлбар хийв.

11. Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайханы гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “1.3.5.Төвийн бүс – “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 1.3.5.7 дахь дэд заалт нэмэх:

“1.3.5.7. Дарханы арьс ширний үйлдвэрийг барьж дуусгах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан саналаа тайлбарлав.

12. Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1. “Уул уурхай” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.1.15 дахь заалт нэмэх:

“3.3.1.15. Нүүрс-химийн технологийг эзэмших, боловсон хүчнээ бэлтгэх, ирээдүйн томоохон төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулан хийн түлш, нийлэг материал, ус төрөгч гарган авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13. Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.3. Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 3.3.3.42 дахь заалт нэмэх:

“3.3.3.42. Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга саналаа тайлбарлав.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн тавьсан асуултад “Дарханы арьс ширний цогцолбор” төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Жамух хариулж, тайлбар хийв.



Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Төслийн 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монголын Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч дарга, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Сонор, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Санхүү хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын зөвлөх Д.Мөнхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ч.Сарантуяа нар байлцав.

Төсвийн төслийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Төсвийн төсөл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан, Б.Уянга, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот, Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Л.Хосбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Л.Эрдэнэбадрах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч дарга, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан Л.Отгонтуяа, Р.Рэнцэнбаатар, Н.Ууганбаатар, А.Энхбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Соноор, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Санхүү хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын зөвлөх Д.Мөнхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ч.Сарантуяа нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 00 минут үргэлжилж, 21 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 80.9 хувийн ирцтэйгээр 16 цаг 44 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

АЖ ҮЙЛДВЭРЖИЛГИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин  
Д.Сүхбаатар” танхим 13 цаг 44 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**С.Ганбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хурэлцэн ирсэн байна. Ирцийг та бүхэнд танилцуулъя.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн ирсэн байна. Далайн Батбаяр 5 дугаар тойрог ирсэн байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн 6 дугаар тойрог ирсэн байна. Дамбын Батлут 4 дүгээр тойрог ирсэн байгаа. Ирцэд орчихсон. Сайнхүүгийн Ганбаатар 1 дүгээр тойрог ирсэн байна. Пүрэвжавын Ганзориг жагсаалтаар, ирсэн байна. Цэрэнпилийн Даваасүрэн 4 дүгээр тойрог энэ хуралдаан давхцаж байгаа байх. Хажикбэрийн Жангабыл ирсэн. Жаргалсайханы Золжаргал ирсэн байна, 9 дүгээр тойрог, Ганзоригийн Лувсанжамц ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан 7 дугаар тойрог ирсэн байна. Ганбатын Очирбат ирсэн байна. Буяагийн Тулга 5 дугаар тойрог ирсэн байна. Болдын Уянга ирсэн байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа 4 дүгээр тойрог ирсэн байна. Дашицэрэнгийн Энхтүвшин ирсэн байна. Мөнхчулууны Энхцэцэг ирсэн байна.

Ирц хангалттай бүрдсэн учраас хуралдааныг эхлүүлъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог нэрээр нь танилцуулж байна. Танилцууллаа хойшид ингэж танилцуулах болно.

Хэлэлцэх асуудлаа та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын Засгийн газрын 2024 оноос 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

Хоёрт нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төслүүд Засгийн газар 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлгийг хийнэ.

Гуравт нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Ингээд та бүхэн хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно оо. Монгол Улс ажлын хэсэг бүгдээрээ байраа эзлэхийг хүсэж байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оноос 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Би та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сайд нар ор ирсэн байх ёстой шүү. Туваан сайд, Энхбаяр сайд 2.

Сайд нарыг орж ирэхлээр би бүрэлдэхүүнийг бүгдийг нь танилцуулна.

Оролцох ажлын хэсгийн нэрсүүдийг танилцуулъя.

Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Ж.Энхбаяр ХХААХҮ-ийн сайд, Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Магнайсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас С.Сүхбат Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, Э.Батболд Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга, Б.Анхбаяр Газрын тосны бодлогын газрын дарга, Х.Санчигдорж Геологийн бодлогын газрын дарга, М.Мэндбаяр Уул уурхай бодлогын газрын дарга Мэндбаяр ирсэн байна уу? Б.Отгонцэцэг Санхүүгийн хэлтсийн дарга, Д.Отгонбаяр Хүнд үйлдвэрийн бодлогын газрын ахлах шинжээч, Р.Батгэрэл Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын зөвлөх, ХХААХҮЯ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр бас давхардаж байгааг ойлгож байна. Тэгэхдээ яаралтай ирүүлээрэй. Манай Байнгын хорооныхон бас дуулгаарай. Л.Идэрцогт Санхүү, хөрөнгө оруулалтын дарга, Ц.Амгалан Ерөнхий санхүүч, А.Гэрэлзаяа ЖДҮ-лэлийн газрын Бодлого зохицуулалтын газрын дарга, С.Цэнд-Аюуш Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД ирсэн байна. Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД. Мөнхзулыг дуудаарай. Алимаа ирчихсэн байх шиг байна. Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга, Пүрэвдоржийн Оюунаа Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Отгонтогтохын Энхмөнх Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Жангабыл, Жаргалсайхан. Жаргалсайхан гишүүнээр, Батбаяр гишүүнээр тасаллаа. Жангабыл гишүүний микрофоныг нээж өгнө үү.

**Х.Жангабыл:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд аливаа хийгдэх ажлуудыг агуулгаараа оруулсан гээд хариулт өгөөд байгаа юм. Тэгээд ингээд ажиглаад үзэхэд агуулгаараа бүх юм орчихсон байгаа. Гэхдээ бас тодорхой тусгах ажил байна. Энэ эдийн засгийн энэ бодлогын хүрээнд 3.3.2.20 дахь заалт болгон нэмж тусгах Даянгийн боомтыг хатуу хучилттай автозамаар холбох, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ гэж тусгах ийм саналтай байна. Энэ томъёоллоор санал хурааж өгвөл зүгээр байна гэж хэлэх байна. Ийм саналтай байна.

**С.Ганбаатар:** Жангабыл гишүүн зарчмын зөрөөтэй санал гаргаж байгаа бол та эндээс бүүр цаасаар заавал өгөх ёстой шүү. Бичгээр өгөх ёстой.

Жаргалсайхан гишүүний микрофоныг нээж өгье.

**Д.Жаргалсайхан:** Би бас энэ 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн ажлын хэсэгт бол байгаа. Гэхдээ бас Байнгын хороон дээрээ хэд хэдэн саналыг бас хэлж протоколд үлдээе. Бидний хувьд бас энэ айл өрхүүдэд тэр тусмаа малчин өрхүүдэд орлогыг нэмэгдүүлэх тал дээр бас нэлээн ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна. Эдийн засаг өсөж байгаа гэсэн ч яг айл руу эдийн засаг орж чадахгүй байна. Тэр тусмаа малчин өрх рүү. Тэгээд Монгол Улс 250 мянган малчин өрхтэй. Тэгээд малын гаралтай түүхий эд бол ер нь жалганд хаягддаг хог дээр хаягддаг болсон. Үүнийхээ хэрээр бол ард иргэдийн амьдрал ахуй маш их ядуурч байна. Тэр ч үүднээс энэ Дарханы арьс



ширний боловсруулах үйлдвэр гэдэг энэ заалт байхгүй байгаад байгаа юм. Энийг оруулах шаардлагатай. Мөн дээрээс нь цагаан идээг боловсруулах асуудлууд их чухал байгаа. Энийг төрөөс яаж дэмжих юм бэ? Энэ бол нэгийн 3.5.1 дээр орох байх. Бүүр тодорхой зааж оруулах байх.

Мөн дээрээс нь энэ аймгууд дээр баригдсан жишээ нь Өвөрхангай аймаг дээр баригдсан тэр арьс шир боловсруулах үйлдвэр гээд байж байгаа юм. 1 сая арьс шир гээд. Энийг яаж үйл ажиллагааг нь жигдрүүлэх тал дээр ямар бодлого байх юм. Одоо бид нар барьчихсан юмаа ашиглаж чадахгүй байгаад байна шүү дээ тэ? Тэгэхээр барьчихсан байгаа юмаа яаж цааш нь ажиллуулах хэвийн горимд нь оруулах дээр ямар бодлого барих вэ. Энэн дээр бас манай яамдууд яг энэ үйлдвэрийн хүчин чадлаар нь ажиллуулах дээр бас бодлого оруулсан нь зөв байх гэсэн ийм 2 саналтай байгаа юм.

Дараа нь энэ 1.4.1.7 дээр сумын төвийн шинэчлэлийн асуудал яригдаж байгаа юм. Бас энэ заалт ерөөсөө байхгүй. Монгол Улс 330 сумтай. Тэгээд энэ суманд хүүхдүүд байгаа, малчид байгаа, багш нар, эмч нар гээд л бүхий л хүмүүс байгаа. Энэ төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай тэр тусмаа залуучуудыг тэнд тогтвор суурьшилтай ажиллуулах дээр энэ сумын төвийн шинэчлэлийн асуудал, сургууль, цэцэрлэг энэ соёлын төв энэ байгууллагууд инженерийн дэд бүтцэд холбогдох асуудал байгаа. Нэгдсэн инженерийн дэд бүтцэд. Тэр суманд орон сууцад амьдрах тэр бололцоо нөхцөлийг хангах асуудал байгаа. Энэ сумдуудыг бас хатуу хучилттай авто замаар холбох асуудал байгаа.

Тэгэхээр энэ талын юмнууд ерөөсөө ороогүй байна. Энийг 1.4.1.7 дээр бүүр тодорхойлон зааж оруулах шаардлагатай байгаа. Зам дээрээс нь авто замын асуудлууд байгаа. Авто зам

дээр бас сая ингээд хилийн боомтуудыг холбох гээд асуудал ярьж байна. Хангайн бүс дээр энэ аялал жуулчлалын 5 цагариг гэж яриад байгаа. Тэр тусмаа энэ Баянхонгор, Архангайг холбох асуудал их чухал байна. Баянхонгор, Архангай аймаг хоорондоо 192 км зайтай. Үүнийг хатуу хучилттай авто замаар холбосноор аялал жуулчлал бас Баянхонгор аймаг руу очиж байгаа. Говийн бүс нутаг, Хангайн бүс нутгийн бас энэ 5 цагаригийн нэг нь болох болов уу гэж ингэж тооцож байгаа учраас Баянхонгор, Архангай гэж зааж оруулмаар байна. Ийм санал байна.

Дараагийн асуудал энэ төрийн болон орон нутгийн өмчит компаниудыг цөөлөх асуудал байгаа. Энэ аль ч засгийн үед яригддаг. Тэгээд ер нь одоогийн тоогоор 5537 аж ахуйн нэгж байна. Мааш өндөр тоо. Ашигтай ажилладаг нь мааш цөөхөн. Тэгээд энэ төрийн өмчит энэ орон нутгийн өмчит компаниуд ерөөсөө өдөр ирэх тусам нэмэгдэж байна. Тэгээд бидний энэ төсвийн удирдлага дээр ингээд харахаар байнгын төрөөс ажлууд хийгдэж байгаа. Энэ нь дандаа ТӨК-уд орон нутгийн өмчит компаниуд руу нэр заагдаад явж байгаа. Тэгээд ашигтай ерөөсөө ажилладаггүй. Тэгээд төсвийн энэ зардлыг ингээд данхайлгаж байдаг. Тэгээд энийг цөөлөх асуудал дээр бид нар бодлогоор энэ үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах ёстой. Энэ 3.1.2.4 дээр орох байх.

Дараагийн асуудал энэ татварыг бууруулах асуудал. Бид нар ярихгүй бол болохгүй. Тэр тусмаа яг тодорхой чиглэл дээр.

**С.Ганбаатар:** Хэнээс тодруулж асууж байгаа билээ? Санал, асуулт яваад байна. Жаргалсайхан гишүүний нэмэлт минутыг өгье өө.

**Д.Жаргалсайхан:** Ингэхээр бидний хувьд бол энэ татварыг бууруулах дээр тэр тусмаа малын гаралтай түүхий эд боловсруулаад эцсийн бүтээгдэхүүн

болгосон компанийн татварыг бууруулах асуудлыг тодорхойлж заамаар байна. Ингэж байж малын гаралтай түүхий эдийг боловсруулж ААН-үүдийн үйл ажиллагаа идэвхжих гээд байна гэсэн ийм бодол санаа байна. Энийг оруулах шаардлагатай байна.

Дараагийн асуудал энэ татвар ярьсан дээр энэ АМНАТ-ын асуудал байгаа. Энэ 4 жилийн хөтөлбөр дээр юу яригдаж байгаа вэ гэхээр үндсэндээ бид нар 93 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортод гаргаж байгаа. Энэ бүтээгдэхүүнийг боловсруулах асуудал л яригдаж байгаа. Тэгэхээр энэ АМНАТ-ын асуудал бид нар ярьж байж энэний асуудлыг ер нь нэг тийш нь болгож байж энэ боловсруулах үйлдвэрүүд яригдана. Энийг 2024-2028 оны мөрийн хөтөлбөр дээр оруулмаар байна, тодорхойлж оруулмаар байна. Энэ дээр ямар бас хариулт өгөх вэ гэсэн ийм 2 асуудал байна.

Дээрээс нь энэ АМНАТ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр явж байгаа.

**С.Ганбаатар:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас саяын 2 асуултад бас хариулъя. Мөн Энхбаяр сайдыг бас яаралтай дуудаарай бас хуралдаан давхцаж байгааг ойлгож байгаа. Тэгэхдээ манайхан зар өгөөрэй. Туваан сайдын микрофоныг өгье. Ажлын хэсгийн микрофон хэд дээр байна. 6 дугаар микрофоныг өгчихсөн байна. Хэд юм Магнайсүрэн даргын микрофон 9-ийг өгье.

**С.Магнайсүрэн:** Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Төрийн нарийн бичгийн дарга Магнайсүрэн.

АМНАТ-тай холбоотой асуудлаар Сангийн яам тус яам 2 багагүй судалгаа хийж байгаа. Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулах хүрээнд АМНАТ-ын асуудал бол нэлээн нарийн

тооцоо судалгаа хийгдэж Ашигт малтмалын хуулийн нэг том бүлэг болж орсон. Гэхдээ 2 өөр хандлага чиг явж байгаа.

Нэгдүгээрт АМНАТ-ын хуулийг бол заавал Ашигт малтмалын хуульд тусгайлан бүлэг болгож оруулах шаардлагагүй. Татварынх нь хуульд явуулж байя гэдэг нэг ийм санал Сангийн яам бас ярьж байгаа. Тэгээд энэ асуудал бид нар энэ намрын чуулганы хугацаанд асуудлыг оруулж ирж Их Хуралд хэлэлцүүлнэ. Ингэхдээ бол гишүүдийн ярьж байгаагчлан АМНАТ-ыг аль болох давхардуулахгүй. ААН бизнес эрхлэгчдэд аль болох таатай байх чирэгдэлгүй хүргэх тийм байх талаас нь бид нар бодож байгаа. Сангийн яамтай энэ талаар бид нар саналаа зөвшилцөлд хүрээд Их Хуралд танилцуулна гэж ингэж бодож байна. Би ингэж үзэж байгаа.

**С.Ганбаатар:** Далайн Батбаяр гишүүн асуултаа асууж, үг хэлнэ үү?

**Д.Батбаяр:** Санал бас хэлж болно. Би энэ зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм. Цөмийн энергийн комиссын тухай энэ нөгөө 2024 оны төсвийн өөрчлөлтүүдийн хуулийг дагаж орж ирж байгаа энэ нөгөө Цөмийн энергийн тухай хуульд 10.2 дээр нь.

**С.Ганбаатар:** Батбаяр гишүүн ээ энэ 3 дахь асуудал дээр орж ирнэ. Тэр үед нь та асуучих уу? Хэлэлцэх асуудал дээр орж ирээгүй байгаа шүү.

Гишүүд асуулт асууж, үг хэллээ.

Та бүхэндээ дараагийн тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрөөтэй саналууд ирсэн байгаа. Тэрийгээ одоо танилцуулж та бүхнээс санал хураалгана. Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Д.Үүрийнтуяа, Б.Уянга, Жангабыл гэсэн ийм гишүүд санал ирсэн байгаа. Ирсэн дарааллаар нь та бүхэнд танилцуулж

байна. Гишүүдээс ирүүлсэн саналыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20 дахь хэсэгт заасны дагуу санал ирүүлсэн дарааллын дагуу санал хураалтыг явуулна.

Хуулийн зохицуулалтыг одоо энэ эхний хуралдаан учраас би бас та бүхэнд уншаад танилцуулсан нь дээр байх гэж бодож байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.20-д төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцох тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй гэсэн ийм заалттай юм байна лээ шүү. Энэ чинь хуультай юм байна лээ тэрийг нь танилцуулъя. Ингээд эхний саналыг та бүхэнд танилцуулаад санал хураая.

Эхний санал Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатараас ирсэн байна. 2024 оны 8 сарын 19-ний 15 цаг 45 минутад ирсэн байна.

Зүйл, хэсэг, заалтын гарчиг дээр Өмнөтгэл хэсэг эдийн засгийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн хүрээнд гээд тэгээд саналын утга нь эдийн засгийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 13 дахь мега төслийг хасах гэж орж ирсэн байгаа. Энэ дээр та бүхний саналыг эхлээд нөгөө эхний нөгөө саналыг нь хураалгах уу?

Мөн энэ дээр 13 дээр Үүрийнтуяа гишүүн бас санал гаргасан байна. Үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 13 дахь төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөх саналтай байна. Алт цэвэршүүлэх үйлдвэр гэсэн ийм санал орж ирсэн байна.

Дараа нь Б.Уянга гишүүнээс Эдийн засгийг тэлэх төслүүдийн жагсаалтын 13 Оюу Толгойн орд нь зэс, алтны орд бөгөөд алт цэвэршүүлэх үйлдвэр барьж байгуулах тохиолдолд технологийн хувьд эхлээд заавал зэс дээр боловсруулалт явагдана.

Энэ маш чухал зүйл ярьж байгаа юм шүү. Эхлээд заавал зэс дээр явагдана. Иймээс Оюу Толгойд төсөлд түшиглэсэн алт цэвэршүүлэх үйлдвэр барина гэдэг нь агуулгын хувьд мөн боломжийн хувьд асуудал дагуулна гэж хэлсэн байгаа. Ингээд Оюу Толгой төсөлд түшиглэсэн алт цэвэршүүлэх үйлдвэр гэдгийг алт цэвэршүүлэх үйлдвэр гэж өөрчлөх гэсэн нэг ийм 3 дахь санал хүлээн авсан цагийг нь би та бүхэнд бас танилцуулах ёстой байх. 2024 оны 8 сарын 20-ны 11 цаг 23 минутад ингэж ирсэн байна.

Энэ эхний саналаар Ганбаатар гишүүний саналыг та бүхэн дэмжиж байгаа бол дэмжсэн гэдгээр санал хураалт явуулъя. Хэлэлцүүлэг байхгүй биз дээ? Саналаа гаргасан хүмүүс нь үг хэлж болно.

Тулгаа гишүүний зөв шүү тийм. Энэхүү саналтай холбогдуулж асуулт асууж, саналаа тайлбарлах энэ санал гаргасан гишүүд нь л саналаа тайлбарладаг юм байна шүү. Зүгээр асуулт асуухгүй биз дээ? Асуулт асуудаггүй юм байна. Санал гаргасан гишүүд нь саналаа тайлбарлах юм байна.

Үүрийнтуяа гишүүн энэ дээр саналаа тайлбарлах уу? 13 шүү. 3-уулаа 13 дээр, тийм.

**Д.Үүрийнтуяа:** Баярлалаа. Эдийн засгийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх энэ 14 мега төслийн 13 дахь төслийн нэрийг өөрчлөх саналыг гаргасан. Энэ дээр бол Оюу Толгой түшиглэсэн гэдгийг алт цэвэршүүлэх үйлдвэр гэдгээс Оюу Толгой түшиглэсэн гэдгийг нь авах санал гаргасан. Нэгдсэн чуулганы үеэр би бас



Эдийн засгийн хөгжлийн яамнаас энэ чиглэлээр тодруулж асуусан. Ер нь бол бид нар алт цэвэршүүлэх үйлдвэр барих нь шаардлагатай юу гэвэл Монгол Улсад шаардлагатай гэж үзэж байгаа.

Өнөөдөр Монголбанканд тушааж байгаа нэг 17, 18 мянган тонн алтны эргэлт байна бидэнд. Үүнийгээ бид нар цэвэршүүлээд явах юм бол илүү их эдийн засгийн ач холбогдолтой гэдэг нь ойлгомжтой. Харин Оюу Толгойн баяжмал түшиглэж хийнэ ээ гэвэл түрүүн Уянгаа гишүүний санал дээр бас гарсан байна лээ. Эхлээд бид нар баяжмалаас алтаа салгаж авахын тулд баяжмалаа хайлуулж боловсруулах ёстой. Тэгэхээр хайлах боловсруулах процесс яваагүй байхад алт цэвэршүүлэх тухай асуудлыг бид нар ярих боломжгүй болчихоод байгаа. Тэгэхээр Оюу Толгойн баяжмалыг хайлуулж боловсруулсныхаа дараа цэвэршүүлэх асуудал яриад байгаа юм уу? Аль эсвэл энэ төсөл нь өөрөө Монголбанканд ирж байгаа хэмжээгээр өөрөөр хэлбэл бидний алтны зах зээлийн эргэлтэд байгаа энэ хэмжээгээр 17, 18 мянган тонныг цэвэршүүлэх тухай асуудал яригдаад байгаа юм уу гэдэг нэгдүгээрт тодорхойгүй байсан. Тэгээд энийг бол явцын дунд бас тодруулахад ер нь бол энэ Оюу Толгойг түшиглэсэн алтны үйлдвэр биш байна гэж ойлгогдоод байгаа.

Тийм учраас энэ нэршлийг нь Оюу Толгойд түшиглэсэн гэдэг нэрийг нь аваад, харин магадгүй эхний ээлжид одоо байгаа Монголбанканд ирж байгаа алтаа цэвэршүүлэх цаашид Оюу Толгойн баяжмалын тодорхой хэсгийг хайлуулж цэвэршүүлдэг болсон цагт түүнээс бас алтаа цэвэршүүлэх ийм боломж байх юм гэдэг үүднээс энэ Оюу Толгойг түшиглэсэн гэдэг энэ тодотголыг нь авах нь зүйтэй байна гэсэн ийм зарчмын зөрөөтэй саналыг оруулж байгаа.

**С.Ганбаатар:** Уянгаа гишүүн саналаа тайлбарлах шаардлагатай бол та тайлбарлах уу?

**Б.Уянга:** Та хэддээ энэ өдрийн мэнд хүргэе. Сая Үүрийнтуяа гишүүнтэй ер нь санал нэг. Миний эхний санал давхцаж байгаа юм байна. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулна гэдгээрээ оруулсан нь зүйтэй гээд тэгээд Оюу Толгой төслийг түшиглэн гэдгийгээ заавал ингэж тодотголдоо оруулах шаардлагагүй юм. Тэгэхээр үндэслэлээ их сайн тайлбарлачихсан учраас давтаад хэрэггүй байх. Би хоцорч орж ирсэн учраас сүүлийнхээ нэг саналыг нэлээн хоцроод ажлын хэсэгт өгчихлөө. Уучлаарай. Тэр маань болохоороо хийн хоолойн байгалийн хийн хоолойн төсөл гээд нөгөө 3 улс орсон. Орос, Хятад, Монгол нийлээд 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөн дээр хүртэл ороод явж байсан энэ төсөл маань манай Засгийн газрын хөтөлбөр дээр огт тусгагдаагүй ороод ирчихсэн байгаа. Тэгээд энэ маань зүгээр нэг тийм мэдээллийн урсгалын алдаа байж магадгүй юм.

2024 оны 5 сард Засгийн газрын хуралдаанаар бол юу тэр хоолой барих гэж байгаа яг хоолой нь хаагуур явах юм бэ гэдэг тэрийгээ батлуулаад авчихсан. Тэгээд одоо бол хөрөнгө оруулалт нь орох нь тодорхой ийм ажил байгаа. Тэгээд ингээд бид нар чинь их тийм хэцүү нөхцөл байдал геополитикийн яг тийм сонирхолтой орчинд амьдардаг учраас 2 хөрштэйгөө хамтарсан энэ төслөө Засгийн газрынхаа хөтөлбөрт дурдаад явах нь зүйтэй. Ажлын хэсэг нь ажил нь саадгүй явуулж байгаа учраас гэдгийг би уг нь нөгөө асуулт асуух боломж байсан бол ЭХЯ-аас өөр яг энэ Эдийн засгийн хөгжлийн яамнаас ч юм уу яагаад энэ төслийг оруулаагүй юм бэ аль нэг тал нь зөвшөөрөхгүй ээ цааши нь явуулахгүй ээ гэсэн зүйл байгаа юм уу гэж асуух байлаа. Гэхдээ яг ажлын хэсгээс авсан яг энэ саналын томъёоллоор бэлдэж байх үед

авсан мэдээллээр 2 тал БНХАУ, Орос хоёулаа ямар нэгэн байдлаар татгалзсан зүйл байхгүй. Үнэ тариф дээр л нэг тохирч байгаа нэг асуудал байгаа юм байна лээ. Тэгэхээр энийгээ бүгдээрээ Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрт оруулаад явах нь зүйтэй гэдгээр нэг ийм 2 дахь саналын томъёолол байгаа шүү. Өмнөх 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө дээр 2.2 заалтаар энэ үйл ажиллагааг дэмжигдээж дэмжиж оруулсан байсан. Тэгээд энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт огт ороогүй байгаа учраас энэ алдаагаа бид нар засах нь зүйтэй байгаа. Тэгээд 1 зарчмын зөрөөтэй саналын 2 дахь томъёолол маань энэ юм шүү.

**С.Ганбаатар:** Уянгаа гишүүний хэлж байгаа бас зөв шүү. Энэ дээр харин дэгээрээ яамдууд энэ дээр тайлбар өгч болох юм байна шүү. Саяын зүйл дээр тодруулга хэлж болно шүү. Яамдууд энэ дээр тодруулах уу? Микрофон 8.

**С.Сүхбат:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Сүхбаатарын Сүхбат гишүүний асуултад хариулъя. 2016-2020, 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Оюу Толгойд түшиглэсэн зэсийн баяжмал хайлуулан боловсруулах үйлдвэрийг барьж байгуулахаар тусгасан байдаг. Мөн алт цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулахаар тусгасан. Алт цэвэршүүлэх үйлдвэртэй холбоотойгоор Сумъяабазар сайдын үед ТЭЗҮ батлагдсан байдаг.

Дараа нь одоогийн Эрдэнэт үйлдвэрийн ерөнхий захирал Ёндон сайд, сайд байх үедээ энэ батлагдсан ТЭЗҮ-д хөндлөнгийн шинжээч гаргаж дүгнэлт гаргуулсан байдаг юм байгаа юм. Тэгэхээр энэ дүгнэлтэд энэ ТЭЗҮ нь бүхэлдээ тооцоолол муутай ашиггүй ТЭЗҮ болсон байна гээд энэ ажил маань саатсан. Энэ үйлдвэрлэл одоогоор СХД-ийн нутаг дэвсгэрт үйлдвэрээ байгуулахаар газраа авчихсан байдалтай байгаа. Оюу Толгой

төслийг түшиглэсэн хайлах үйлдвэр дээр Үүрийнтуяа гишүүнтэй санал нэг байна.

Эхлээд зэсийн баяжмалаа хайлуулаад, боловсруулаад энэ явцдаа алт зэс гээд бусад бүтээгдэхүүнүүдийг гаргаж авдаг учраас энэ Үүрийнтуяа гишүүн болон Уянгаа гишүүдийн саналтай санал нэг байна гэж хэлэх байна.

**С.Ганбаатар:** Би бас санал гаргасан учраас саналаа тайлбарлая. Энэ мега төслүүд 14 мега төслийн хүрээнд ярихад бол ил тод байна, сонирхлын зөрчлөөс ангид байна, Монгол Улсын эдийн засагт нийтлэг эрх ашгийн төлөө байна гэсэн заасан байгаа. Энэ бол анхны удирдамж дээр нь байгаа. Тэгээд энэ дээр би энийг илүү өргөн хүрээгээр авч үзье ээ гэсэн байдлаар би дараагийн томъёолол нь энэ чинь нөгөө цаг хугацаагаар орж ирсэн учраас эхлээд энийг нь танилцуулж байгаа юм.

Дараагийнх дээр бол түрүүн тэр Үүрийнтуяа гишүүнийхтэй санал нэг байна. Миний оруулж ирэх гээд байгаа санал гэвэл зэс баяжуулаад зэсээ боловсруулаад дараад нь алтыг нь цэвэршүүлж авдаг болохоос биш ерөөсөө шүд сугалж байгаа юм шиг алт авна гэдэг юм энэ дээр ороод ирсэн байна. Уянгаа гишүүний байр суурь дээр тэр тайлбар дээр ч гэсэн энэ гарчихсан байна лээ. Тэгэхлээр томъёолол бол Монгол орны зэсийн ордуудыг түшиглэн тэр ганцхан Оюу Толгой биш ганцхан тийм нэр томъёо ярьж болохгүй энэ дээр энэ чинь. Монгол төрийн бодлого явж байгаа. Одоогийн байдлаар 5 орд явж байгаа. Тавуулан дээр нь хамаатайгаар бид бодлогоо гаргах ёстой. Ганцхан Оюу Толгой дээр биш. Тэгээд Монгол орны зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах зэс болон бусад эрдэс элементүүдийг цэвэршүүлэх үйлдвэр байгуулах гэж томъёоллоор орж ирэх ёстой. Тэрэн дээр би ингээд бас эрдэмтэдтэй бол судлаад ингээд ярьж

байхад бол энэ дээр ганцхан алтны тухай бид ярих гээд байгаа байхгүй юу. Тэгтэл алт мөнгө, рени, сүрма цаана нь дахиад 7 нэр томьёо байгаа шүү дээ. Энэ асуудлуудыг нь бид бас бодлогын хувьд хаячих гээд байна. Энийг нь оруулж томьёолъё л гэж би санал оруулж байгаа юм.

Хоёрдугаарт манай дээр бол одоо 9.9 тэрбум тонн хүдэр байгаа зэсийн хүдэр. Бүгдээрээ өмнөд бүстэй байгаа ихэнх нь. Тэгэхлээр олон улсын практикт бол мэргэжилтэн, судлаач эрдэмтэд нь бас бид боломжийг нь өгөөд энэ дээр ийм ерөнхий бодлогын томьёоллоо оруулъя гэдэг утгаар ганцхан Оюу Толгой ганцхан алт гэж туйлширахгүйгээр нийтлэг эрх ашгаар нь оруулъя гэж дараагийн санал орж ирэх байгаа. Нөгөө хугацааны хувьд дараагийнх нь арай хоцроод өгчихсөн юм байна.

Ингээд эхний томьёоллыг эдийн засгийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 14 дэх мега төслийг хасах дараа нь бүүр дэлгэрүүлж томьёолох гэдэг ийм томьёоллоор би эхний саналыг хураая.

Ингээд санал хураалт.

Компьютер татгалзсан байна.

Дараагийн саналуудыг танилцуулъя та бүхэнд. Үүрийнтуяа гишүүний санал. Тэгвэл одоо ганцхан Оюу толгой дээр ганцхан шүд сугалж байгаа юм шиг алтыг нь сугалж авна л гэдгээр бодлого гарч байгаа юм байна шүү дээ. Тийм таны гаргасан санал гаргах гэж байгаа юм байна. Яах вэ санал уначихсан энэ дээр хамаагүй би дахиж хураалгахгүй. Зүгээр хамгийн гол нь та нар нүдний булай болно шүү. Зэсийг баяжуулахгүйгээр энэ чинь Оюу Толгой чинь зэс, алтны орд шүү. Зэсийг нь баяжуулахгүйгээр яаж та нар алт ялгаж авах гээд байгаа юм? Тэрийг нь би томьёоллоор дараагийн томьёоллоор

орно. Энэ дараалал нь яах вэ одоо гаргасан санал дээрээ.

Дараагийн санал. Үзэл, бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн хүрээнд тайлбар нь саналын утга нь үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 13 дахь төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөх саналтай. Алт цэвэршүүлэх үйлдвэр. Зэсийг нь хаяж байгаа юм уу тэгээд? Алт цэвэршүүлэх гэж ийм ийм санал орж ирж байна. Ингээд саналыг дэмжиж байгаа нь саналаа өгнө үү? Түрүүн ярьчихсан биз дээ дахиж ярихгүй биз дээ?

Үүрийнтуяа гишүүний санал 58.8 хувиар дэмжигдсэн тул Дэгийн хуулиараа Уянгаа гишүүний саналыг бас хураахгүй юм байна шүү.

Дараагийн санал эдийн засгийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн хүрээнд энэ миний дараагийн санал.

Саналын утга нь бол эдийн засгийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 10 дахь төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөх гэж байгаа.

Монгол орны зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах зэс болон бусад эрдэс элементүүдийг цэвэршүүлэх үйлдвэр байгуулах гэсэн ийм санал байна.

Энийг дэмжиж байгаа гишүүд нь саналаа өгнө үү.

Энэ дээр дараагийн санал нь Үүрийнтуяа гишүүний санал байна. Яг утга нь ойролцоо юм байна. Үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 10 дахь төслийн нэрийг Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах цогцолбор гэж өөрчлөх саналтай байгаа юм байна. Нэр нь бас ингэж орж ирсэн байна.

Ингээд 2 саналын эхний орж ирсэн саналаар. Тайлбарлаж болно шүү. Үүрийнтуяа гишүүн. Үүрийнтуяа гишүүн саналаа тайлбарлая.

**Д.Үүрийнтуяа:** Мөрийн хөтөлбөрийн төсөл дээр орж ирэхдээ Зэс боловсруулах цогцолбор гэдэг нэрээр орж ирсэн. Үндсэндээ бид нарын энэ хийх гээд зориод байгаа асуудал маань зэсийн баяжмалаа хайлуулж боловсруулах асуудлыг ярих гэж байгаа юм. Зэс боловсруулах цогцолбор гэдэг бол гарчихсан эцсийн бүтээгдэхүүн зэсээрээ дараагийн шатын бүтээгдэхүүн үйлдвэрлэх тухай үйлдвэрийн тухай асуудал яригдаад байгаа учраас нэр томъёоны хувьд өөрчлөх шаардлагатай юм байна гэж үзэж байгаа. Одоо бол зэсийн баяжмал Оюу Толгой болон Эрдэнэт үйлдвэрийн хувьд баяжмал гаргаж байна. Эрдэнэт үйлдвэр жилдээ нэг 600 орчим мянган тонн зэсийн баяжмал Оюу Толгой нэг 800 орчим мянган тонн зэсийн баяжмал гаргаж байгаа. Тэгэхээр энэ зэсийн баяжмал хайлах боловсруулах үйлдвэр гэдэг нэрээрээ тэгээд энэ боловсруулах цогцолбор гэдэг нь яах вэ гэхээр эцсийн дүндээ бол энэ хайлах үйлдвэрээс гарч байгаа катодын зэсээрээ зэс бүтээгдэхүүн хийх, зэс утас, зэс кабель, дараагийн зэсээр хийх бүтээгдэхүүн хийх үйлдвэрийн энэ химийн үйлдвэртэй нь дагалдах байдлаар нь хамтад нь цогцолбор байдлаар зэсийн баяжмал хайлах боловсруулах үйлдвэрийн цогцолбор гэдэг байдлаар о оруулах нь зүйтэй юм гэсэн байдлаар саналыг томъёолсон байгаа.

Энэ арын тайлбарууд дээр би бас дараагийн саналуудаа бас давхар оруулж өгсөн. Тэрийг дараагийн санал хураалт дээр бас тайлбарлаад явъя гэж бодож байна.

**С.Ганбаатар:** Үүрийнтуяа гишүүний саналыг сонслоо. Энэ саналтай

холбогдуулаад бас яам байр сууриа тайлбар өгөх үү? Микрофон 8.

**С.Сүхбат:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Сүхбат. Яах вэ зүгээр бидний зүгээс яг тухайн аж ахуйн нэгж гэдэг шиг нэр зааж өгмөөр байгаа юм. Тухайлбал Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газарт түшиглэсэн үйлдвэрлэл технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна гэдэг үгээр оруулбал бас зүйтэй болов уу гэж бодож байна. Манай яамны зүгээс бол энэ саналаа хүргүүлсэн байгаа.

**С.Ганбаатар:** Үүрийнтуяа гишүүн энэ дээр бас тодруулна.

**Д.Үүрийнтуяа:** Яамны байр суурьтай адил саналтай байна. Сүхбат даргын томъёолж байгаа томъёоллыг арын нөгөө хүрэх үр дүн дээр нь томъёолж оруулах юм бол илүү бодитой юм болов уу гэж бодож байгаа. Би яах вэ энэ саналын томъёоллууд энэ зарчмын зөрүүтэй саналуудыг гаргаж саналын томъёоллыг гаргахдаа би бас Байнгын хорооны ажлын албатай зөвлөсөн зарчмын хувьд. Тэгээд яалт ч үгүй нөгөө оруулж байгаа асуудал дээр Дэгийн хуулиар би бас өөр өөрчлөлтүүдийг оруулах боломжгүй байгаад байгаа юм. Хэрвээ миний санаж байгаа төлөвлөж байгаагаар болдог бол энэ 14 мега төслийг харуулаад байгаа энэ хүснэгтийг өөрийг нь өөрчилмөөр байгаа юм. Тэгээд энэ өөрчлөх саналаа би ажлын хэсэг рүү албан бичгээр хүргүүлнэ. Яг энэ 14 мега төсөл дээр төслийн нэрээс гадна ард нь хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь орхигдоод байгаа юм. Тэгээд хэрэгжүүлэх арга хэмжээ ямар хугацаанд хийгдэх юм, ямар үр дүнд хүргэх юм. Ийм байж байж яг бодитой мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагааны хөтөлбөрийн томъёолол болж орж ирэх болов уу гэж харж байгаа. Тэгээд Сүхбат даргын томъёолж байгаа энэ томъёолол бол хэрэгжүүлэх



арга хэмжээ дотроо байх оновчтой заалт гэж би харж байна.

**С.Ганбаатар:** Энэ дээр би саналаа тайлбарлая. Ер нь ганцхан Оюу Толгой ч гэдэг юм уу Эрдэнэт ч гэдэг юм уу ингэж хавтгайрч болно гэж байхгүй. Зэсийн бусад олон ордуудад бас боломжийг нь бид өгөх ёстой шүү. Бусад ордууд энэ чинь яам бодлогоо хэрэгжүүлж л байгаа бол бусад ордуудад бас зэс хайлах ганцхан алт биш бусад эрдэс баялгуудаа бас цэвэршүүлэх боловсруулах тэр боломжийг нь нээж өгөх гэж өнөөдөр бодлогын баримт бичигтээ тусгаж байгаа шүү. Энэ утгаараа миний хувьд бол Монгол орны зэсийн ордуудыг түшиглэн тэр дотор чинь Оюу Толгой, Эрдэнэт 2 орж байгаа шүү дээ. Түшиглэн зэсийн баяжмал хайлуулах зэс болон бусад эрдэс элементүүдийг цэвэршүүлэх үйлдвэр байгуулах гэж. Тэгэхгүй зүгээр ингээд бид бодлогоо боловсруулахдаа зөвхөн 1, 2 ордод зориулж болохгүй ээ гэдгийг би зарчмын хувьд хэлээд ингээд нэрээ өөрчлөх саналуудыг би танилцуулъя.

Санал. Монгол орны зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах зэс болон бусад эрдэс элементийг цэвэршүүлэх үйлдвэр байгуулах гэсэн ийм саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Пунсалмаа гишүүн микрофонд хэлчих үү? Пунсалмаа гишүүн горимын санал гаргая гэж байна.

Микрофон ажиллаагүй учраас дахин санал хураалгаж явуулъя гэдэг санал орж ирж байна. Тэгвэл төхөөрөмж ажиллаагүй учраас дахин санал хураалгаж өгнө үү гэсэн ийм саналын томъёоллоор дахин санал хураалгая. Энэ саналыг хүчингүй болгох гэсэн саналын томъёоллоор санал хураая.

64.7 хувиар саяын саналыг хүчингүй болгох саналын томъёоллоор санал хурааж дэмжигдлээ.

Сая дэг тайлбарлаж байна. Саналын томъёолол энэ холбогдох асуудал болгон дээр бас асуулт асууж, тайлбар авч болно гэж байна шүү. Ингээд Золжаргал гишүүн түрүүн бас нэг хэдэн гишүүн байсан, Тулга гишүүн байсан уу? Тулгаа гишүүн, Жаргалсайхан гишүүн байсан байх тийм ээ? Өөр гишүүд байна уу? 3 гишүүн Золжаргал гишүүн, Тулга гишүүн, Жаргалсайхан гишүүн, Уянгаа гишүүн Бадамсүрэн гишүүн. Бадамсүрэн гишүүний нэрийг оруулчхаарай. Баярлалаа. Золжаргал гишүүний микрофоныг өгье.

**Ж.Золжаргал:** Би нөгөө томъёолол тус болгон дээрээ юу асуух юм болов уу гэж бодож асуусан юм. Тэгээд саяынх дээр бол дэмжээд дэмжчихсэн байгаа. Тэгэхээр томъёоллын юун дээр бол дэмжчихсэн нөгөө хойд талд нь байгаа хүрэх үр дүн гэдэг хүснэгт дээр харин саяын өгүүлбэр чинь бас байх ёстой юм болов уу? Одоо энэ дээр бол 560 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэнэ гээд ингээд тоо тавьчихсан байгаа шүү дээ. Эрдэнэтийн аж үйлдвэрийн паркийн мэдээ яг ингээд тоогоороо орчихсон байгаа. Дараагаар нь Оюу Толгой, Хармагтай, Цагаан суварга, магадгүй ирээдүйд дахиад бий болох 2, 3 сая тонн зэсийн баяжмалын юуг яах вэ гэдэг тэр асуудлаар түрүүн санал хураагаад нэр өөрчлөөд дэмжчихсэн. Тэгэхээр энд энэ дотроо бас тэр нь байх ёстой юм болов уу л гэж бодоод байна л даа.

**С.Ганбаатар:** Яамнаас энэ дээр тайлбар өгөх үү?

**С.Сүхбат:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. Сүхбат 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр ярьж байгаа учраас энэ 4 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлаа бид Эрдэнэтийн хайлах хүдрийг барьж байгуулах боломжтой юм гэж үзэж байгаа юм. Тэгэхээр ерөнхий нэрээрээ сая Золжаргал гишүүний ярьсан

байж болох байх. Яг ард хаалт дотроо Эрдэнэт гээд заагаад өгчихвөл боломжтой болов уу гэж үзэж байгаа юм. Оюу Толгой хармагтай тэгээд Цагаан суваргын ордуудын бэлтгэл ажил явагдаж байгаа учраас дараагийн шатанд хэрэв энэ судалгааныхаа явцдаа боломжтой гэж үзэх юм бол эдгээр 3, 4 ордын зэсийн баяжмалыг нэгтгээд бас өөр Монгол Улсад дахиад 2 дахь хайлах үйлдвэр барьж байгуулах боломж нөхцөл байгаа гэж үздэг. Үүнийгээ ч Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан Аж үйлдвэржилтийн үндэсний хорооны ийм зэсийн дэд хороон дээр санал, дүгнэлт гаргасан ийм явцтай байгаа.

**С.Ганбаатар:** Тайлбарыг авлаа. Тулга гишүүн.

**Б.Тулга:** Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг эрвэ.

Тэгэхлээр түрүүн бас горимын санал дээр нөгөө яах вэ зарчмын зөрүүтэй санал дээр хэлэлцүүлэг явуулъя гэдэг хүсэлт тавьсан байсан. Ингээд болчихлоо. Тэгэхдээ яах вэ эхний санал хураалт бол яг ба микрофонгүй хэлэлцүүлээд явчихлаа шүү дээ. Энэ дээр бол энэ Байнгын хорооны хүмүүсээс асуумаар байгаа юм. Энэ зарчмын зөрөөтэй саналуудыг энэ гишүүдэд тарааж өгч бас танилцах боломжоор уг нь хангаж өгч цаашаа явбал зүгээр байна. Бид нар бас эхний хурал учраас тэр байхгүй учраас тэндээс уншаад нөгөө тогтоож авч тэмдэглэж авч амжихаас өмнө маань Ганбаа дарга дарга маань бас хурдан уншдаг учраас түрүүлээд явчхаад тэгээд сонсох гээд байсан юм. Тэгэхлээр сая ерөнхийдөө бас нэг заалт дээр хэд хэдэн гишүүн бас зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа учраас хэдүүлээ аль юу гэдэг юм оновчтой гэж бодогдож байгаа дээр саналаа өгөөд явж байгаа гэдэг ийм байр суурийг хэлэх гэсэн юм. Сая энэ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны даргын бас хэлж байгаа тайлбарт Засгийн газрын гишүүний хувиар санал нэг байна.

Энэ бол бид нарын Ганбаатар даргын хэлж байгаа ер нь бүх л үйлдвэрүүд дээрээсээ гарч байгаа бүтээгдэхүүнийг дахин боловсруулах илүү өртөг шингээж үлдээх, шингээх гэдэг дээр бол 100 хувь санал нэг байгаа. Тэр ч утгаараа энэ дээр мөрийн хөтөлбөр дээр бол боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих гээд явж байгаа. Гэтэл тэрийг бол хувийн хэвшил хийж болно. Бусад янз янзын хэлбэрээр байж болно. Зарчим бол манай энэ Засгийн газар дээр бол 2024-2028 онд бас тодорхой судалгаанууд хийгдчихсэн. Ажил нь эхэлчихсэн энэ ажлуудыг ажил хэрэг болгож дуусга гэдэг үүднээсээ энэ 10 дугаар мега төслийг оруулсан байгаа. Ерөнхийгөөр орох юм бол 2028 онд нөгөө Засгийн газрын үйл ажиллагааг дүгнэх гэхээр үгүй та нар чинь бүх үйлдвэрийг ингэх ёстой байсан ганцхан үйлдвэр дээр явж байна гэдэг маягаар бас үнэлгээн дээр асуудал гарна.

Тийм учраас тодорхой төслийг энэ 14 дотор оруулсан байгаа. Даргын хэлж байгаа ер нь энэ боловсруулах үйлдвэрүүдийг цааш нь илүү түүхий эдээр нь биш боловсруулж гаргах гэдэг заалт бол 3.3 дээр байгаа байх тийм ээ. 3.3.1.1 дээр мөрийн хөтөлбөрийн эдийн засгийн төрөлжилт либералчлалын эхний заалт боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй дэмжиж экспортын орлогыг нэмэгдүүлнэ гэсэн энэ заалтад нөгөө ерөнхий утгаараа зэсийн уурхайнууд бусад уурхайнууд энийгээ гүнзгийрүүлэх ёстой гэдэг ийм санаа явж байгаа. Энэ дээр манай яам сая маш тодорхой хэллээ. Энэ тооцоо судалгаа бас тодорхой хэмжээнд ажил явчихсан. Энэ юунуудаа 2028 ондоо багтааж ашиглалтад оруулах гэдэг заалт байгаа учраас эхний нэрийг бол зарчмын зөрөөтэй саналыг дэмжиж байна. Нөгөө баяжуулах гэдэг үг оруулсан байсан шүү дээ? Тийм ээ. Шууд зэс хайлуулах цогцолбор биш зэсийн баяжмалыг боловсруулж цогцолбор гэдэг дээр бол таны саналыг дэмжиж байна. Ганбаа даргын санал та 2 нийлээд бас болчих юм байна. Тийм учраас хурал

даргалагчаас зарчмын зөрүүтэй санал болгон дээрээ санал хурааж авах юм уу дундаа нийлээд энэ томъёоллоо нэг болгоод хураалгах юм уу гэдэг дээр бас тийм Байнгын хорооноос тайлбар авмаар байна.

**С.Ганбаатар:** Тулга гишүүний саналыг ойлголоо. Дэгийн хуулиараа түрүүн тайлбарласан. Яг эхний цаг хугацаагаар орж ирсэн. Тэгээд бүгдийг нь хураалгана бүгдийг нь асууна. Эхнийх нь дэмжигдчихвэл дараагийнх нь хураагдахгүй гэсэн нэг тийм л дэгтэй юм байна лээ шүү түрүүн танилцуулсан. Ингээд Жаргалсайхан гишүүний микрофоныг өгье.

**Д.Жаргалсайхан:** Би түрүүн нөгөө санал гээд л тэгэнгүүт саналуудаа хэлчихсэн. Миний саналуудыг санал хураалт хийх үү? Нэг дэх асуудал.

Хоёрт нь бол энэ саяын яг энэ хэлэлцээж байгаа асуудал дээр бол таны яг саналыг яг тодорхойлон дэмжиж байгаа юм. Ганцхан нэр заахгүйгээр энэ чинь хэд хэдэн газрууд бас зэсийн баяжмал байгаад байна шүү дээ. Тэрийгээ боловсруулах гээд явах нь дээр болов уу гэсэн энэ дээр санаа. Тэгээд томъёоллоо та нэг яг санал хураалгахаас өмнө нэг дахиад нэг хэлмээр байна тийм. Тэгвэл нөгөө хүмүүс эргэлзээж тээнэгэлзэхгүй шүүд зөвшөөрсөн, татгалзахаа хэлээд явмаар байна гэсэн ийм юутай байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Ойлголоо.

Тийм асуулт асуусан. Тэр саналуудаа бичгээр өгөх юм байна лээ шүү. Зарчмын зөрүүтэй саналуудаа бичгээр заавал өгнө гэсэн дэгтэй юм байна лээ. Жаргалсайхан гишүүн ээ. Шүүд микрофонд өгөөд зүгээр орхичих биш бичгээр өгөх юм байна лээ.

Уянга гишүүн.

**Б.Уянга:** Ганбаатар даргын томъёолол ер нь зөв л дөө. Тэрийг дэмжиж байгаа. Гэхдээ 2024-2028 онд хэрэгжчихээд эхлээд болчих нь энэ томъёоллын хүрэх үр дүн дээр бичигдсэн болов уу гэдэг агуулгаараа Үүрийнтуяа гишүүний саналын томъёоллыг дэмжээд явсан юм байгаа юм шүү. Магадгүй яг таны томъёоллоор 2028-2032 оны хөтөлбөрт яг тэрүүгээрээ орох нь зөв байх. Хэрэгжчих зүйл заалт болчих болов уу гэж бодож байна.

Хоёр дахь нь болохоороо Эдийн засаг хөгжлийн яамны Анар дарга ороод ирчихсэн байгаа учраас. Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны манай Анхбаяр дарга 2-оос нөгөө байгалийн хийн хоолойн төслийн агуулга яагаад Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусаагүй юм бэ гэдгийг асууя. Анар дарга бол ерөнхийдөө мэдээж сайн мэдээж байгаа байх. Аль нэг хөршөөс маань энийг бүтэхгүй гэсэн нэг тийм агуулгаар юу гэдэг юм мэдээлэл ирсэн юм уу? Энэ 2-т маань хоёулаа яг холбогдох 2 газрын дарга нь хариулаад өгөөрэй. Анар дарга болон Анхбаяр дарга.

**С.Ганбаатар:** 5 дугаар микрофоныг өгье.

**Б.Анхбаяр:** Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Уянгаа гишүүний асуултад хариулъя. Байгалийн хийн хоолойн төсөл бол яг одоогийн байдлаар ямарваа нэгэн гацаа үүсээгүй явж байгаа. Саяхан Засгийн газрын хуралдаанаар бол газрынхаа зөвшөөрлийг төслийн нэгж дээр авчихсан байгаа. Одоогийн байдлаар яг төсөлтэй холбоотой нийт төслийг цааш нь хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсон хүчнийг бэлдээд явж байгаа. Манай талаас шаардлагатай бүх ажлууд нь хийгдээд явж байгаа. Түрүүн асуусан асуулт дээр бол 2 тал ямарваа нэгэн байдлаар зогсооно гацаана гэсэн зүйл бол ерөөсөө байхгүй байгаа. Хятад болон ОХУ дээр бол яг ажлууд нь нэлээн эрчтэй өрнөөд явж байгаа. Нийт одоогийн

байдлаар 20 гаруй уулзалтыг 2 талаасаа ажлын хэсэг байгуулчихсан хийгээд явж байгаа юм байна лээ. Тэгэхээр ерөнхийдөө энэ төсөл цаашид нэлээн эрчимтэй явах байх. Яг энэ төслийг манай яамнаас яг шууд гардаж хариуцаж ажилладаггүй. Энэ болохлоор Шадар сайдын ажлын албан дээр ерөнхийдөө удирдлага нь яваад Эрдэнэс Монгол нэгдэл дээр төслийн нэгж үйл ажиллагааг нь хийгээд явдаг. Бид нар бодлогын түвшинд ерөнхийдөө дэмжлэг үзүүлээд явж байгаа. Энэ дээр бол яамны зүгээс бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан тохиолдолд бол ямарваа нэгэн тийм татгалзах зүйл байхгүй.

**С.Ганбаатар:** Бадамсүрэн гишүүн гараад явчав уу? Очирбат гишүүний микрофоныг өгчихье дөө. Тэгээд тасаллаа шүү.

**Г.Очирбат:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе.

Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр гэж явж байгаа шүү. Яамныхан аягүй сайн анхаараарай. Тэгээд энэ хөтөлбөрийн энэ хүрэх үр дүн дээр дандаа энэ тоо баримтуудыг тусгаад байгаа. Энэ Оюу Толгойтой холбоотой Зэс боловсруулах үйлдвэрт алт боловсруулах үйлдвэртэй холбоотой, Зэс боловсруулах үйлдвэртэй холбоотой гангийн үйлдвэртэй холбоотой. Тэгэхээр зэс баяжуулах үйлдвэр гэж ерөнхийд нь барих ёстой юм уу. Яг энэ тоог чинь харахаар Эрдэнэтийг түшиглээд гаргачихсан байдаг. Гангийн үйлдвэр гээд 11-д бас байгаа. Гангийн үйлдвэр чинь энэ яг Дарханы үйлдвэрийг барьж тоо судалгаа гаргаж энэ тоог энэ хүрэх үр дүн дээрээ бичсэн юм уу. Тэгэхээр энэ нэр томъёогоо яг энэ Дарханыг түшиглэж байгаа бол Дархан гээд биччих хэрэгтэй. Зэс боловсруулах үйлдвэртээ Эрдэнэт гэж байвал Эрдэнэтээ бичих хэрэгтэй. Оюу Толгойг алтан дээр яг Оюу Толгойн алтны нөөц дээр алт баяжуулах үйлдвэр гэж тооцсон бол энийгээ бичиж явахгүй

бол цаашаагаа дандаа цаашаагаа алдаа гарна шүү. Яаман дээр очоод шат шатны байгууллагууд дээр очоод ерөнхий нэг зэс боловсруулах үйлдвэр зэс баяжуулах үйлдвэр гээд тэгчихдэг. Тэгвэл одоо Оюу Толгой дээр зэс баяжмал дээр яах юм. Хармагтайгийнх гээд та нар ирээдүйд юу гэж бодож харж байгаа юм.

Яг Эрдэнэт дээр тооцоо хийчихдэг. Ингээд 3 тал руу булаацалдаад яваад байх вий дээ. Яамныхнаас асуух гэсэн юм. Энэ дээр нэр томъёо дээр та хэд маань энэ үйл ажиллагааны хөтөлбөр шүү. Яг тодорхой зааж явахгүй бол дараа нь асуудал гардаг шүү. Яамнаас хариулчаарай.

**С.Ганбаатар:** 5 дугаар микрофонд өгье. 8 байна шүү.

**С.Сүхбат:** Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яамны газрын дарга Сүхбат. Гишүүнтэй санал нэг байна. Гэхдээ таны ярьж байгаа зүйл бол энэ хөтөлбөр батлагдсаны дараа Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө гэж хардаг. Энд тодорхой суух ёстой юм байгаа юм. Манай яамны зүгээс Эдийн засаг хөгжлийн яам руу 2 төслийн нэр явуулсан. Эрдэнэтийг түшиглэсэн, Дарханыг түшиглэсэн, гангийн болон зэс хайлах үйлдвэрийг 2024-2028 оны хүрээнд барьж байгуулна гэдэг агуулгаар явуулсан байгаа. Энэ хөтөлбөр дээр одоогийн байгаа энэ хөтөлбөрийн төсөл дээр болохоор яг манай тэр явуулсан саналыг тусгаагүй ерөнхий байдлаар оролцсон юм байгаа юм. Тэгэхээр энийг хэлэлцүүлгийн явцад энийг яг тодорхой болгоод явчих байх. Яагаад Оюу Толгой дээр ер нь аж үйлдвэрийн салбарын томоохон мега төслүүд говийн бүсэд байгаа юм. Дорноговь, Өмнөговь, Зүүн бүс гэх юм бол Сүхбаатар, Хэнтий гээд. Эдгээр бүсүүд дээр бид энэ мега төслийг барихад 2 зүйл хамгийн их дутагдаад байгаа.

Энэ нь юу вэ гэхлээр номер нэгд усны асуудал. Усаа шийдэж чадахгүй бид



нар зэсээ хайлуулж чадахгүй. Үүнтэй холбоотойгоор 2 дугаар асуудал нь эрчим хүчний асуудал. Энэ 2-ын асуудлыг шийдсэн тохиолдолд бид энэ томоохон мега төслүүдээ урагшлуулах боломжтой. Бодлогын баримт бичгүүдийн хувьд бид тодорхой судалгаануудыг нэлээн ахицтай хийсэн байгаа гэдэг агуулгаар байгаа. Улсын Их Хурлын гишүүдээс Мөнхбаясгалан гишүүн яг энэ усны асуудал дээр бас нэлээн сайн анхаарч байгаа учраас манай яамны зүгээс мэргэжлийн түвшинд та бүхэнтэй хамтраад энэ усны асуудал дээр бас нэлээн дэмжлэг үзүүлээд явагдах бас бүрэн боломжтой байгаа гэдгээ бас давхар хэлье. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Очирбат гишүүн тодруулъя.

**Г.Очирбат:** Би зүгээр энэ ерөнхий энэ том мега 14 төслийг бодлогын хувьд бүтэн дэмжиж байгаа. Тэгэхээр яамдуудын мэргэжилтнүүд энэ дарга нар байгаа болохоор та хэдийн ажил цаашаа явах ёстой тийм биз? Явахын тулд нэр томъёогоо нарийвчилж зааж өгөөрэй гэдгийг л хэлээд байгаа шүү тэрийгээ аягүй сайн ойлгоорой. Тэгэхгүй бол дараа нь ингээд ерөнхий ингээд юмнууд явдаг булаацалддаг тийм ээ энд тэнд очоод нэг нь нэг юм яриад нөгөөдөх нь өөр юм яриад ажлыг чинь ингээд замхруулчихдаг шүү. Тэгэхээр яамныхан бүгд энд орж ирээд сууж байгаа. Яг энд сууж байгаа Байнгын хороон дээрээс энэ нэр томъёоны асуудал дээр анхаарал өгөөд яг тодорхой явсан нь дээр. Одоо жишээ нь би бол тэр алтыг Оюу Толгой гэж харж байгаа шүү. Яг бодитойгоор. Өнөөдөр Монгол Улсын алт хамгийн их хаанаас яаж орж ирж байгаа гэдэг тооцоо судалгаа яаман дээр байгаа тийм ээ. Тэгэхээр Оюу Толгой гэдэг нэр томъёо орж ирж байгаа гэж хувь гишүүнийхээ хувьд харж байгаа юм. Тэгээд Оюу Толгойг түшиглэж энийг хийх юм яг энэ хөтөлбөрт нь Оюу Толгойг нь суулгаад өгчих ёстой байхгүй юу. Үгүй бол төвийн бүс дээр ч гэдэг юм уу одоо манай

СХД дээр алт боловсруулах үйлдвэр гэж ярьж байгаа юм. Яах вэ төв рүүгээ татаж авчирч ирэх ийм бодлого яваад тэр ТЭЗҮ дээр нь алдаатай байсан гэдэг нэг ийм дүгнэлт гаргачхаад тэрүүгээрээ яваад байгаа юм шиг байгаа юм. Тэгэхээр яамныхандаа л хандаж хэлээд байгаа юм шүү. Асуудлаа тодорхой нэр томъёо нь тодорхой байвал та хэдийн ажил цаашаа явахдаа их тодорхой явна шүү. Тэгээд та хэдийн ажлыг бүрэн дэмжиж байгаа. Усны асуудал дээр бол манай говиос сонгогдсон гишүүд бүтэн дэмжиж байгаа. Парламентын бүх гишүүд дэмжиж байгаа. Эдийн засгаа бид нар тэлэх ёстой. Зорилго нь ерөөсөө л ДНБ-ээ 5800-аа 10 мянга болгоё гэж байгаа. Монгол Улсын нийт эдийн засгийг 2 дахин тэлье гэж байгаа. Тэлснээрээ энэ ард иргэдийн маань аж ахуйн нэгж ард иргэдийн маань яг карманд нь орж байгаа тэр бодит орлогыг нэмэгдүүлэхийн тулд эдийн засгаа том утгаар нь нэмж энэнээс олж байгаа үр өгөөжөө хамтдаа улс орон даяараа иргэд юу гэдэг юм ААН бүгд л хүртье гэж байгаа юм. Тэгэхийн тулд та хэд ажлаа явуулах ёстой. Ажлаа явуулахын тулд нэр томъёо чинь тодорхой байх ёстой шүү гэдгийг л дахин дахин хэлээд байгаа юм шүү. Тэгээд яамныхан байр сууриа яг тодорхой илэрхийлээд яг энэ тоон судалгаа хаана гарсан тоон дээрээ энийг түшиглэж ийм тоо гарсан юм. Тэгэхээр нэр томъёогоо ингээд тодорхой явчихъя гэдэг байр сууриа илэрхийлээрэй.

**С.Ганбаатар:** Очирбат гишүүний санал чухал. Тэгээд дараа дараагийн асуудал дээр бас гарч ирнэ.

2 дугаар асуудал дээр саналаа хураалгая.

Зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах зэс болон бусад эрдэс элементүүдийг цэвэршүүлэх үйлдвэр байгуулах гэсэн ийм саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэ санал 35.3 хувиар дэмжигдсэнгүй.

Өөрөөр хэлбэл тэгвэл Оюу Толгой, Эрдэнэтэд зориулъя. Бусад нь хамаагүй ээ л гэсэн үг болж байна шүү дээ. Дараагийн саналаа танилцуулъя.

Үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 10 дахь төслийн нэрийг Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах цогцолбор гэж өөрчлөх саналтай байна. Санал гаргасан Үүрийнтуяа гишүүн. Саналын томъёоллоор санал хураая. Энэ санал 58.8 хувиар дэмжигдлээ.

Дараагийн саналаа танилцуулъя. Санал гаргасан С.Ганбаатар гишүүн.

Мега төслийн 9 дэх нүүрс-хими, кокс-химийн цогцолбор гэсэн төслийн хүрэх үр дүнгийн хүснэгтийн кокс-химийн үйлдвэр гэсний доор нүүрс-химийн технологийг эзэмших, боловсон хүчнээ бэлтгэх, ирээдүйн томоохон төслийн техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулж, хийн түли, нийлэг материал, устөрөгч гарган авна гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар.

Энэ дээр санал хураалт явуулъя. Асуулт асууж болно, тайлбар авч болно шүү. Яамныхан харин хариулна шүү тэрэн дээр. Би өөрөө бас саналаа тайлбарлана. Энийгээ хурал дээр танилцуулдаг юм байна. Урьдчилж өгдөг юм уу үгүй юу? Урьд нь. Яаралтай дэгээр бол хамаагүй гэж байна шүү. Тайлбаруудыг нь өгье. Ямар ч байсан гишүүдэд бас танилцуулах ёстой шүү энэ бол. Уянгаа гишүүн бас асууна гэсэн нэрийг нь оруулаарай. Уянгаа гишүүн, Золжаргал гишүүн. Өөр саналууд байна уу? Энэ дээр тодруулж асуух. 2 гишүүн. Золжаргал гишүүн.

**Ж.Золжаргал:** Би нэмэлт мэдээлэл өгье гэж бодож байсан юм энэ юун дээр яамныхан бол нүүрс химийн талаар их олон төслүүд олон санаачилгууд явж байгааг бүгдээрээ сайн мэдэж байгаа. Тэгээд манайхан чинь бараг 50 жил Монгол Улсад нүүрс химийн үйлдвэрлэл хөгжүүлнэ гээд ярьж байгаа улсууд. Ерөөсөө болдоггүй юм. Арван хэдэн жилийн өмнө Монголын хэдэн том компаниуд бүгдээрээ тус тусдаа ТЭЗҮ, зураг төсөл хийсэн. Зарим нь бүүр төслийн бэлтгэл ажил хийсэн. Төрийн яамны дэргэд бас ажлын хэсэг гаргаад 2 ч төсөл хийгдсэн. Бүгд бэлэн цаасан дээр зураг төсөл байдаг төслүүд. Тэгээд нүүрс химийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ гэдэг нь бодлогын баримт бичгүүд нь бүгдээрэн дээр нь тусгагдсан байгаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 90.3.1.14 дээр бас байгаа. Энэ хүснэгт дээр болохоор тэр нь тодорхойгүй байгаа. Тэгэхээр зэрэг тэр аливаа том юмыг хийхийн тулд эхлээд өөрсдөө цоо шинэ дээрээс нь бас аюул осолтой байж болохуйц тэртээ тэргүй хийх нь тодорхой ийм зүйлийг хийхийн тулд бэлтгэл шатад хагас үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нь ерөөсөө олон улсын жишиг. Ямар ч том үйлдвэрлэл дээр. Тэгээд энийгээ бас бэлтгэгдсэн төсөл судалгааны юмнууд байгаа учраас оруулж өгөх гэсэн тэр зарчмын саналыг дэмжиж байгаа юм. Тэгээд энэ талаар яамныхан ямар байр суурьтай байгаа юм болоо гэдгийг нь л сонирхож байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** 8 дугаар микрофон.

**С.Сүхбат:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын дарга Сүхбат.

Золжаргал гишүүнтэй санал нэг байна. Энэ нүүрсийг боловсруулж диметиллийн бүтээгдэхүүн гаргах энэ төсөл өмнө нь яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээр орж ирж байсан. ТЭЗҮ нь дэмжигдсэн. Гэхдээ байрилын хувьд Налайх дүүрэгт

Тавантолгой түлшийн түшиглэгч байгуулахаар тусгасан байсныг бид нар энэ Тавантолгой дээр энэ туршилтын үйлдвэрийг бас байгуулах боломжтой юм гэж үзэж байгаа. Гишүүнтэй санал нэг байна.

**С.Ганбаатар:** Уянга гишүүний микрофоныг өгье.

**Б.Уянга:** Эхний асуулт маань сая Золжаргал гишүүн давхцаад асуусан учраас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны яг энэ асуудлаа хариуцаад хэрэгжүүлээд бодлогыг нь гаргаад явах баг хамт олон хэрвээ болно дэмжиж байна гэж байгаа тохиолдолд дэмжье гэсэн агуулгаар асуух гэж байсан юм. Тэгээд тэр маань боломжтой гэсэн хариултыг авлаа гэж ойлголоо.

Хоёрдугаарт нь болохоороо манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн бас сайд маань сууж байгаа болохоор нэг зүйлийг заавал хэлээд бас нэг бодлого гаргаж байгаа эсэхийг нь асууя. Тэр нь болохоор их олон том том хүнд үйлдвэрийн аж үйлдвэрийн төслүүд бид нар оруулж ирж байна. Хажуугаар нь давхар боловсон хүчнээ бас бодохгүй бол болохгүй. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн ажил төлөвлөгдсөн байгаа юу? 2024-2028 онд.

**С.Ганбаатар:** Туваан гишүүний микрофоныг өгье.

**Ц.Туваан:** Энэ том томоохон мега төслүүдээ бид нар манайд байгаа Үйлдвэр технологийн паркийн хуулийн дагуу үйлдвэр технологийн парк байдлаар шийдэхээр ингээд зорилтууд тавьчихсан. Тэгээд эн тэргүүнд энэ зэс хайлуулах үйлдвэр, гангийн үйлдвэрлэл, нүүрс хими гээд ингээд ерөнхийдөө 6 газар үйлдвэр технологийн парк байгуулж шийднэ гээд ингээд зорьж байгаа. Энэ дээр бас байришил юу байришлын хувьд бодолцсон нэг асуудал энэ боловсон хүчний асуудал байгаа. Тэгээд энэ дээр жишээлэх юм бол зэс хайлуулах үйлдвэр энэ үйлдвэр

технологийн паркийг Эрдэнэтэд гээд тэрэн дээр бол бид нарт бэлэн бэлтгэгдсэн бас боловсон хүчний асуудал байгаа. Тэгээд ер нь бол бүх асуудлууд дээр бүхий л салбар дээр Монгол Улсад энэ боловсон хүчин хүний нөөцийн асуудал бол маш хүнд болчихсон юм билээ. Тэгэхээр энэ дээр бас бид нар нэлээн асуудлыг тавьж шийдвэрлэх ийм зайлиггүй шаардлага байгаа. Яг манай салбар дээр бол энэ дээр мэдээж одоо яг бодлогын түвшинд асуудлууд нь явж байгаа.

Тэгэхээр энэ дээрээ бас цаашдаа анхаарч ажиллана.

**С.Ганбаатар:** Асуултдаа гишүүд 2 дугаар асуулт дээр гишүүд тайлбаруудаа авлаа. Ингээд саяын ярьсан томьёоллоор дахиад би уншихъя. Мега төслийн 9 дэх нүүрс-хими, кокс- химийн цогцолбор гэсэн төслийн хүрэх үр дүнгийн хүснэгтийн кокс химийн үйлдвэр гэсний доор нүүрс химийн технологийн эзэмших боловсон хүчнээ бэлтгэх ирээдүйн томоохон төслийн техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулж, хийн түли, нийлэг материал устөрөгч гарган авна гэж нэмэх гэдэг. Томьёоллоор санал хураалт явуулъя. 58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн саналыг хураалгая. Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Үүрийнтуяа гишүүний санал байна.

2024 оны 8 сарын 20-ны 11 цаг 10 минутад өгсөн үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн хүрээнд өөрчлөх саналын утга үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 8 дахь төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөх саналтай. Уран олборлох баяжуулах үйлдвэр гэсэн ийм санал байна. Энэ дээр саналаа Үүрийнтуяа гишүүн саналаа тайлбарлана.

Мөн асуух гишүүд байвал бас асуулт асууж болно. Үүрийнтуяа гишүүний микрофоныг.

**Д.Үүрийнтуяа:** Баярлалаа. Мөрийн хөтөлбөрийн. Энэ 14 мега төслийн 8 дээр томьёолол нь орж ирэхдээ Монгол Францын хамтарсан гурван атомын цахилгаан станц гэж орж ирж байгаа юм. Тэгэхээр Атомын цахилгаан станцыг барьж байгуулах тухай асуудал энэ төслийн нэр томьёо яригдаад байгаа юм л даа. Ард нь хийгдэх гэж байгаа ажил хүрэх үр дүнг нь харахаар бид нар 2500 тонн уран экспортлоно гэдэг томьёолол нь орж ирээд байгаа юм. Ер нь бол одоо байгаа бидний боломж, хүчин чадал, нөөц, ялангуяа энэ Францтай ярьж байгаа асуудал дээр Дорноговийн нэг зэргэлдээ 2 ордын асуудал л байгаа шүү дээ. Тэр хүрээндээ бид нар 2500 тонн ураныг олборлож ураны 2500 тонн ураны баяжмал гаргах л боломжтой байхгүй юу. Тэгэхээр бид нар ураныг тэр баяжуулах үйлдвэрийг л барих тухай асуудал. Тэгээд дараа нь ураны баяжмалаа экспортод гаргах тухай асуудал л ярьж байгаа учраас энэ Атомын цахилгаан станц гэдэг томьёол бол буруу байна гэж үзэж байгаа юм. Тийм учраас энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргаж нэршлийг нь уран олборлох баяжуулах үйлдвэр гэсэн томьёоллоор өөрчлөх саналтай байна гэсэн саналыг оруулж байгаа юм. Бусад энэ атомын цахилгаан станц гэсэн томьёололтой холбоотой ард нь тэр гарах үр дүнтэй холбоотой асуудал дээр би бас тусгайлан дахин зарчмын зөрүүтэй санал оруулсан байгаа. Тэрийг хураах үед нь бас ард нь тайлбарлаад явъя.

**С.Ганбаатар:** Энэ асуудалтай холбогдуулж асуулт асууж тодруулах гишүүд байвал нэрсээ өгнө үү? Мөнхбаясгалан гишүүн, Тулга гишүүн, Жаргалсайхан гишүүн байна. Очирбат гишүүн би бас асууна. Айн Ганбаатар гишүүн гээд ингээд оруулчихъя. Нэр

хаягдаагүй байгаа. Мөнхбаясгалан гишүүн.

**Л.Мөнхбаясгалан:** Саяын энэ асуудал дээр холбогдох яамнаас мэргэжлийн хүмүүсээс асууя гэж бодож байна. Нэр томьёолол юм шиг мөртөө цаанаа асар том өөр асуудал нөлөө хөндөөд байх шиг байна. Монгол Францын хамтарсан уран атомын цахилгаан станц юм уу уран боловсруулж баяжуулах үйлдвэр юм уу яг аль нь вэ? Энэ дээр бүүр яг нухацтай хариулт авмаар байна. Хаана нь вэ? Тайлбар өгье яамнаас тайлбар өгье. Аль микрофон дээр ярих вэ? 9 дүгээр микрофон Очирбат гишүүний нэрийг оруулаарай асуултад.

**С.Магнайсүрэн:** Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр эрдэс баялгийн яам Магнайсүрэн. Энэ асуудал энэ мега төслүүд дээр ер нь манай яамны энэ уран олборлохтой холбоотой баяжуулах үйлдвэртэй холбоотой ашиглах боловсруулах үйлдвэртэй холбоотой асуудал бол манай яамтай холбоотой энэ ч одоо ч явж байгаа ажлууд бий. Зүгээр яг атомын цахилгаан станц гэвэл бас эрчим хүчний яам руу хамаардаг ийм бас ялгаатай ойлголт байгаа. Энэ үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл боловсруулах явцад бол бид нар энэ өнөөдөр явж байгаа Франц улстай хамтраад хөрөнгө оруулалтын гэрээ хийх гээд явж байгаа хэлэлцээр дээрээ үндэслээд саналаа өгсөн байгаа. Засгийн газрын 2028 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөр дээр ямар ч байсан энэ Хөрөнгө оруулалтын гэрээгээ байгуулаад саяын ярьдагчлан тэр ураныг олборлож баяжмалыг гаргахтай холбоотой энэ асуудлыг бол тусгахаар саналаа өгсөн. Атомын цахилгаан станцтай холбоотой асуудлыг манай яам хариулж чадахгүй байна. Яг тийм энийг Эрчим хүчний яам хариулах байх.

**С.Ганбаатар:** Жаргалсайхан гишүүн асуултаа асууя.



Эрчим хүчний яамнаас төлөөлөл ирсэн байгаа, хариулаарай. Аль микрофон дээр хариулах вэ? 3 номер.

**Н.Тавинбэх:** Гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан шинээр баригдах эрчим хүчний эх үүсвэрүүдийн хувьд атомын цахилгаан станцтай холбоотой 3.1.1.7 дээр ураны нөөцийг түшиглэн атомын цахилгаан станц барих бодлого хэрэгжүүлж суурь судалгааг хийнэ гэсэн л ийм томъёолол байгаа. Түүнээс станц барина гэсэн томъёолол би хараагүй байх юм. Тэгээд ч 4 жилийн хугацаанд барьдаг ийм төсөл биш. Энэ бол олон улсын жишгээр 10 орчим жилийн хугацаанд нэлээн их бүтэмжтэй байвал барилга угсралтын ажил дуусдаг ийм төсөл байгаа. Энийг их олон удаа ярьж хэлэлцэж байж шийдсэн. Ер нь урантай холбоотой асуудал бол бол эрчим хүчний ураны нөөцтэй холбоотой асуудал бол Эрчим хүчний яаманд огт харьяалагддаггүй. Хэдийгээр эрчим хүчний эх үүсвэр ч гэсэн хий ураны нөөц бол Эрчим хүчний яаманд харьяалагддаггүй юм. Зүгээр станц барих асуудал дээр бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ийм л заалт тусгагдсан. Суурь судалгааг хийнэ. Өчигдөр Байнгын хороон дээр бол харин энэ суурь судалгааг Засгийн газрын үйл ажиллагааны бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлж ээ гэдэг ийм л санал гарсан. Ийм л байдалтай явж байгаа.

**С.Ганбаатар:** Нэр албан тушаалаа бүгдийг нь микрофондоо бас хэлээрэй. Протокол хөтөлж яваа шүү. Мөнхбаясгалан гишүүн тодруулъя гэж байна.

**Л.Мөнхбаясгалан:** Эртээд бүлгийн хурал дээр жишээ нь энэ атомын цахилгаан станц гэдгийг хөндөхөөр Эрчим хүчний яам 1 ийм дургүй ч юм шиг байр суурь харуулаад байгаа байхгүй юу. 4 жилд хийдэггүй 11 жилд хийдэг гэж эртээд ярьсан л даа. Болно л доо. Хэрвээ

үнэхээр Засгийн газар үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө мега төсөлдөө энд зоогоод оруулаад ирчихсэн юм бол энэ 4 жилд эхлэлийг нь тавиад явуулж болох юм байгаа биз дээ. Эсвэл дургүй байхад чинь хүчээр оруулж ирээд байгаа юм уу? Энэ дээр би дахиад бүүр яг асуучихъя гэж бодож байна.

**С.Ганбаатар:** 5 номерын микрофон. 3 юм байна шүү. 3 номер нэрээ хэлээд албан тушаалаа танилцуулаарай.

**Н.Тавинбэх:** Эрчим хүчний яам Төрийн нарийн бичгийн дарга Тавинбэх гишүүний асуултад хариулъя. Төслийг хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлэхдээ үе шаттай явна. Энэ 4 жилийн хугацаанд суурь судалгааг хийнэ л гэдэг ийм томъёоллоор оруулж байгаа шүү дээ. Хариуцсан салбар яамны хувьд станц барина гэвэл барилга угсралтын ажлыг бүрэн хүлээж авч ашиглалтад оруулна л гэсэн үг.

Тэгэхээр энэ бол боломжгүй 4 жилийн хугацаанд. Тийм учраас суурь судалгааг хийнэ ээ л гэдэг ийм томъёолол оруулж байгаа юм.

**С.Ганбаатар:** Үүрийнтуяа гишүүн энэ дээр тодруулна. Туваан сайд дараа нь тодруулах юм байна шүү.

**Д.Үүрийнтуяа:** Мөрийн хөтөлбөр дээр яг ийм үйл ажиллагааны хөтөлбөр дээр яг ийм томъёолол атомын цахилгаан станц гэдэг томъёолол орж ирээд байгаа учраас би бас энийг нэлээд тодруулсан юм. Ер нь бол атомын цахилгаан станцын түлш буюу хэрэглэх уран чинь тэр U238 гээд нэлээн өндөр чанарын уран юм байна лээ шүү дээ. Өөрөөр хэлбэл манай үйлдвэрлэх гээд байгаа бидний зориод байгаа ураны баяжмалыг дахин боловсруулж баяжуулж байж тэр түлшийг гаргадаг. Тэрнээс биш өнөөдөр бид нарт нэгдүгээрт технологи нь байхгүй, хоёрдугаарт түүхий эд нь байхгүй. Энэ 4 жилийн хугацаанд бол Атомын цахилгаан станц барих тухай

асуудал суурь судалгаа нь ч хийгдээгүй ийм ажил бол үндсэндээ мөрөөдлийн жагсаалт болчих гээд байгаа юм л даа. Атомын цахилгаан станц барихад чинь бас технологийг нь эзэмшдэг 1 2 улс байдаг юм байна гэж ойлгосон. Тэрний нэг нь Франц юм байна. Энэ технологийг тэр технологиор гаргаж авсан тэр маш өндөр шаардлагатай олон улсын гэрээ конвенцод хүртэл нэгдэх ёстой тэр олон улсын стандарт шаардлагыг нь хангаж гэрээ конвенцынх нь заалт бүрийг хэрэгжүүлж байж бид нар энэ Атомын цахилгаан станц барих тухай асуудлыг ярих ёстой юм байна гэж ойлгож байгаа.

Тийм учраас миний хувьд энэ зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг атомын цахилгаан станц гэдэг нэр томъёог нь авч энэ ураны баяжмал үйлдвэрлэх гэдэг тал гэдгээр оруулж ирсэн байгаа шүү гэдгийг бас тодотгож хэлээд энэ мэргэжлийн хүмүүс энэ дээр илүү нарийн тодруулга хэлж өгөх байх гэж бодож байна. Ялангуяа түүхий эдийнх нь хувьд.

**С.Ганбаатар:** Туваан сайд тодруулах гэж байна уу?

**Ц.Туваан:** Бид хэд бас дараа нь ярих байх. Энэ цөмийн энергийн асуудал Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны эрхлэх асуудлын хүрээнд орж ирж байгаа. Бид нар Францтай Орана компанитай хөрөнгө оруулалтын гэрээний асуудал яригдаж байгаа. Ажлын хэсэг нь бас хуралдаад явж байгаа. Тэгэхээр бид хэд бас нөгөө Мөнхбаясгалан гишүүнтэй санал нэг байгаа юм нь энэ асуудлаа бас яриад явъя. Монгол Улсад аж үйлдвэрийн асуудал ярихад үндсэн 2 асуудал маш нэн тэргүүнд тулгамдсан асуудал байгаа. Тэрний нэг нь ус, нэг нь эрчим хүч. Тэгэхээр энэ эрчим хүчний асуудал дээрээ бид нар энэ атомын цахилгаан станц гэдгийг бас яриад явъя гэдэг ийм саналтай байгаа.

Хоёрдугаарт бол мэдээж энэ бид нарын утааны асуудал ард иргэдийн эрүүл мэндийн асуудал бол маш ноцтойгоор яригдаж байгаа. Энэ цаг үед эрчим хүчний өөр эх үүсвэрийг бид нар бас ярихаас өөр аргагүй байгаа юм. Тэгэхээр атомын цахилгаан станцын асуудлыг бол манай яамны хүрээнд бол эхлүүлээд ингээд цааш нь аваад явъя гэдэг ийм саналтай байгаа. Бэлэн одоо жишээ бол манай хажуу дахь Казахстан улсад одоо жишээлбэл уранаа олборлоод Францтай хамтраад дээрээс нь атомын цахилгаан станцын асуудлаа бас шийдээд явж байгаа. Тэгэхээр энэ тал руу яамны байр суурь байгаа.

**С.Ганбаатар:** Туваан сайд сая тайлбар өглөө. Жаргалсайхан гишүүн тодруулъя.

**Д.Жаргалсайхан:** Энэ асуудал дээр бүлгийн хурал дээр Чойжилсүрэн сайд бас хариулт өгч байсан. Хоёр улсын, Оросын холбооны улс бас Монгол Улсын тэргүүнүүд уулзаад энэ асуудлыг ярьсан. Энэ асуудал 2 орны хооронд бол нэлээн ажлууд болоод явж байгаа гэсэн ийм хариултыг өгсөн юм.

Тэгэхээр би энийг бас хэрэгжих ажлын жагсаалт нь байх ёстой байх л гэж бодож байна. Шууд ингээд аваад хаячихна гэдэг бас нэг талдаа арай байж болохгүй болов уу гэсэн ийм саналтай байна.

**С.Ганбаатар:** Тулга сайд.

**Б.Тулга:** Жаргалсайхан гишүүнтэй ерөнхийдөө бас санал нэг байна. Ер нь яах вэ энэ Оронагийн хэлэлцээр явж байхад ч гэсэн яг энэ ашиглах талдаа буюу Монгол Улс өөрөө бага оврын бид нар бол юу гэдэг юм нөгөө Орост гэдэг юм уу Украйнд гэдэг юм уу, Японд байгаа тэр том станцыг одоохондоо ярьж эхлэх арай болоогүй юм байна лээ. Зүгээр бага оврын энэ станцуудыг барьж тодорхой эрчим хүчний хэрэгцээгээ хангах тухай асуудал бол хөндөж байгаа. Нэгэнт ураны

олборлолт ураны баяжмалын олборлолт тийм ээ хийх гэж байгаа тохиолдолд ашиглалтаа давхар бодож явах ёстой. Зүгээр хэлэлцээрт тэр явж байхад бол мэдээллийг харж байхад бол энд яригдаж байгаа тэр станц бол дор хаяж 10-аас 15 жилийн хугацаанд бас барьж байгуулдаг юм байна лээ.

Тийм учраас энэ том төслүүдээ хөдөлгөнө гэж байгаа тохиолдолд нэгэнт одоо олборлолтоо явуулж эхэлж байгаа бол зэрэгцээд барьж байгуулах тэр хэлэлцээр, тооцоо, судалгаа, зураг энэ тэрээ бол хавсраад аваад явах нь зөв байх. Тэгэхээр энэ дээр байгаа тэр яг станц барьж байгуулах гээд Тавинбэх дарга бас хэлээд байна л даа. Яг дуусах болов уу гэж. Тэгэхлээр станц барьж байгуулах суурь судалгаа гэдэг үгээр нь бас байж байх юм бол бид нар нөгөө ОХУ-даа ч тэр Францдаа ч тэр хэлэлцээр хийхэд бас бид нар ийм юм зориод байгаа юм манай мөрийн хөтөлбөрт суучихсан байгаа гэвэл бас илүү ач холбогдолтой юм болов уу.

Тийм учраас та бүхэн бас энэ яг барих гэх юм уу аль эсвэл ард талд нь яах яах вэ суурь судалгаа эхлүүлэх гээд 3.3.3.7 дээр бол байж байгаа юм. Энэ төсөл дээрээ болохлоор ямар сайн олборлолтоо эхлүүлэе зэрэг станцынхаа ажлыг эхлүүлэе гэдэг энэ Жаргалсайхан гишүүний гаргаж байгаа саналтай бас санал нэг байна. Тийм учраас энийг бас эрхэм гишүүд бодолцож үзнэ байх гэж бодож байна.

**С.Ганбаатар:** Очирбат гишүүн.

**Г.Очирбат:** Энэ дээр бас нэлээн тооцоо судалгаатай Монгол Францын хамтарсан уран атомын цахилгаан станц гэж оруулж ирж байгаа. Тэгэхээр хэдүүлээ одоо жоохон хамтарсан засаг явж байгаа. Том амбицтай том төслүүдээ явуулна. Монгол Улсаа хөгжүүлнэ. Сүүлийн 30 жил бид нар газрын доорх баялгаа түүхийгээр нь гаргасаар байгаад өнөөдөр бид нарт алт

цэвэршүүлэх үйлдвэр ярьж байгаа шүү. Гангийн үйлдвэр ярьж байгаа шүү. Бид нар нэг тонн хүдрийг төмөр дээр гэхэд 100 гаранхан доллароор гаргаад, буцаагаад гангаа худалдаж авахдаа 700, 800 мянга орчим доллароор авч байгаа шүү. Манай түүхий эд хилийн цаана гараад боловсруулагдаад буцаагаад бид нар руу орж ирж байгаа. Энийгээ бодоорой.

Зэс дээр яг адилхан алт дээр яг адилхан. Тэгэхээр энд сууж байгаа эрхэм Улсын Их Хурлын гишүүд болон яамныхан энэ дээр тодорхой байгаад амбиц нь ийм тодорхой яг энэ нэршилээрээ Монгол Францын хамтарсан ураны атомын цахилгаан станц гээд явчихвал зүгээр байх. Яагаад гэхээр дэлхий дахинаа эрчим хүчний байлдаан болж байгаа бүгд л мэдэж байгаа. Өнөөдөр Монгол Улс эрчим хүчээ 3, 4 янзаар сэргээгдэх эрчим хүчнийхээ өртгийг тооцож үзэж байна. Нүүрсэн цахилгаан станцынхаа өртгийг тооцож үзэж байна. Дэлхий дээр уран л энэ атомын цахилгаан станц чинь л хамгийн хямд өртөгтэй байгаа шүү дээ.

Тэгэхээр ийм өртөгтэй байгаа шүү дээ. Одоо энэ 2024-2028 оны энэ хамтарсан засаг том том ажлуудаа явуулах ёстой. Нэршил нь тодорхой байх ёстой. Том амбицтай байх ёстой гэдгийг бол Уул уурхай, эрдэс баялгийн яаманд нэгдүгээрт хэлье.

Хоёрт бас Эрчим хүчний яаманд Тавинбэх дарга та бас жоохон том амбицтай байгаарай гэж танд хэлэх гэсэн юм. Яагаад гэхээр одоо бид нар нэгэнт Францууд орж ирээд 2 улсын хоорондох хэлэлцээр явагдаад хамтраад ажиллая энэ ажлыг хөдөлгөө гэж байгаа дээр манай Улсын Их Хурлын гишүүд болон засаг яамдууд нэлээн амбицтай энэ дээр цуг нэг эхлүүлээд явуулчихвал яасан юм бэ? Тийм ээ мэдээж том төсөл хэцүү. Тэгэхдээ яг энэ цаг үе энэ моментыг ашиглаад энэ том төслүүдээ явуулчихвал зүгээр шүү. Тэгээд нэршил нь энүүгээрээ

байгаад 30 жилийнхээ алд алдааг энд давтаж болохгүй шүү гэдгийг л хэлэх гэсэн юм. Бид нар бүх байгалийнхаа үндсэн түүхий эдийг эцсийн бараа бүтээгдэхүүн болгож байж энэ Монгол Улсын эдийн засаг одоогийн яриад байгаагаар бид нар 2 дахин тэлэх буюу нэг хүнд ноогдох ДНБ-ээ 10 мянган доллар болгох гээд л зориод байгаа шүү.

Танд тийм л нэг боломж байгаа. баярлалаа.

**С.Ганбатаар:** Үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 8 дахь төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөх саналтай байна. Уран олборлох баяжуулах үйлдвэр гэж үндсэндээ атомын цахилгаан станцыг хасъя гэсэн ийм саналыг Үүрийнтуяа гишүүн санал гаргасан байна. Саналын томъёоллоор санал хураалт.

Энэ санал 11.8 хувийн санал авч дэмжигдсэнгүй.

Ингээд дараагийн Үүрийнтуяа гишүүний санал бас орж ирсэн байна. Энийг та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн 11 цаг 10 минутад санал өгсөн үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 8 дахь төслийн үр дүн хэсгийн эхний өгүүлбэрийг дараах байдлаар өөрчлөх саналтай байна. Олборлолт боловсруулалт бүрдэх хүчин чадалдаа хүрэхэд 2500 тонн ураны баяжмал экспортлоно гэсэн ийм нэр томъёог оруулсан байна. Та тайлбар өгөх үү?

Үүрийнтуяа гишүүн тайлбарлая саналаа тайлбарлая.

**Д.Үүрийнтуяа:** Энэ саналын хувьд саяын унасан саналтайгаа уялдуулж орж ирсэн санал. Энд нөгөө ураны баяжмал үйлдвэрлэнэ гэдгээрээ ураны баяжмалыг экспортлох гэдэг нэр томъёоны өөрчлөлтийг оруулж ирсэн юм. Тийм учраас би эхний санал унасан учраас энэ саналаа татаж байна.

**С.Ганбатаар:** Саналаа татаж авлаа. Дараагийн санал бас Үүрийнтуяа гишүүний санал байна. Тэрийг уншиж танилцуулъя та бүхэнд.

Үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 9 дэх төслийн хүрээнд үр дүнгийн эхний өгүүлбэрийн өмнө нүүрс-химийн үйлдвэр гэж нэмэх гэж санал орж ирсэн байна. Саналаа тайлбарлах уу?

**Д.Үүрийнтуяа:** Баярлалаа. Тэгэхээр 9 дээр бол нүүрс-хими, кокс-химийн цогцолбор гэж төслийн нэр орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл нүүрс-химийн үйлдвэр, кокс-химийн үйлдвэр. Ингээд цогцолбороороо хөгжих юм байна гэсэн агуулга харагдаж байгаа юм. Кокс-химийн үйлдвэрийг тодорхой үр дүнд хүрсэн үр дүнгээр нь ингээд оруулчхаад байна л даа. Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр шатанд тухайлах юм бол 10 сая тонн коксжих нүүрсийг угааж 5.4 сая тонн баяжуулсан нүүрс 3 сая тонн завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гээд ингээд тодорхой оруулчхаж байгаа юм. Боловсруулах коксынхоо хэмжээг ч тодорхой тавьчихаж байгаа юм. Харин урд талд нь байгаа тэр нэмүү өртөг шингэсэн гэдэг дээр би нүүрс химийн цогцолборын асуудлыг ярих гээд байна уу, нүүрс химийн үйлдвэрийн асуудлыг ярих гээд байна уу гэж ойлгоод байгаа юм.

Тийм болохоор ер нь нүүрс-химийн үйлдвэр гэдэг маань өөрс өөрөөр хэлбэл нөгөө нүүрс угаах л асуудал шүү дээ. Чанарын ялгаатай байгаа нөгөө нүүрсийг нүүрсийг үе шат болгоноос өөрөөр гарсан нүүрсийг угаагаад нэг чанарын түвшинд тэнцвэржүүлэх л асуудал яригдаж байгаа байх гэж ойлгож байна. Тийм учраас энэ эхний томъёоллын дээр нүүрс-химийн үйлдвэр гэдэг агуулгыг нь тодорхойлолтыг нь нэмж оруулъя гэсэн ийм саналтай байгаа.



**С.Ганбатаар:** Тулга сайд асуулт тодруулах асуулт байна уу? Өөр асуултууд байна уу? Тулга сайд.

**Б.Тулга:** Энэ дээр найруулгын хувьд бол гишүүний санал дээр санал нэг байн. Дараа нь тэр нөгөө хүрэх үр дүнгүүд дээр Алтаниширээт үйлдвэрлэл технологийн парк. Энэ дээр бас бусад нүүрс кокс юмнаасаа бусад хүнд үйлдвэрлэлийн бас тодорхой үр дүнгүүд байгаад байх шиг харагдаад байх юм. Тэр утгаараа эхний нөгөө оршил дээд талын хэсэгт нь нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэл гэж ерөнхий биччихсэн байна уу, үгүй юу? Энэ дээр энэ ажлын хэсгийн улсууд бас тодруулж асуумаар байна.

Өөрөөр хэлбэл ялгааг нь гаргаж өгөөч. Энэ ерөнхий байдлаар бичээд хүрэх үр дүнгээ дотор нь ялгачихсан байна уу үгүй юу?

**С.Ганбатаар:** 8 дугаар микрофон.

**С.Сүхбат:** Тулга гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны газрын дарга Сүхбаатарын Сүхбат. Нүүрс химийн үйлдвэрийн хувьд Золжаргал гишүүний гаргасан саналаар тэр диметилийн эфирийн үйлдвэрийг туршилтын үйлдвэр байгуулах боломжтой гэсэн байдлаар санал хураалт сая дэмжигдсэн. Кокс химийн цогцолборын хувьд Тавантолгойн 10 сая тонны хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэрээс кокс эрчим хүчний коксын үйлдвэрийг байгуулах боломжтой байгаа. Энэ нь үйлдвэр технологийн паркийн хүрээнд хийгдэхээр Эрдэнэс Монгол болон Эрдэнэс УТП компанийн хүрээнд хөгжлийн төлөвлөгөө нь боловсруулагдаад дараа 7 хоногт хөгжлийн төлөвлөгөө нь манай яаман дээр ирнэ. Яаман дээр ирсний дагуу бид энд нөгөө үйлдвэр технологийн паркийн зөвлөлөөрөө хэлэлцээд шийдвэр гаргах юм байгаа юм. Ер нь яах вэ Тавантолгойн паркийн хүрээнд бид нар энэ кокс эрчим хүчний үйлдвэрийг бас байгуулах

боломжтой юм байгаа юм. Өөрөөр хэлбэл коксыг гаргах явцад 2 төрлийн ийм бүтээгдэхүүн гардаг. Нэг нь металлургийн кокс, нөгөөдөх нь коксоос эрчим хүч гаргадаг ийм технологитой байдаг. Энэ 2-ыг аль ч тохиолдолд бид нар ашиглаж технологийг нь сонгоод үйлдвэрлэл явуулах боломжтой гэж үзэж байгаа.

**С.Ганбатаар:** Золжаргал гишүүн тодруулъя.

**Ж.Золжаргал:** Нүүрс хими гэдэг томъёолол нь нөгөө нүүрс угааж баяжуулах биш хийжүүлэх шингэн тэгээд нөгөө ус төрөгч хийн түлш энэ тэр гэсэн тэр агуулгаараа байгаа байх л даа. Тэгэхээр тэр агуулгаараа түрүүчийн нөгөө санал дэмжигддэг саналаар бага оврын туршилтын үйлдвэр гээд орчихсон бол би саяынх бараг хариулт нь болчих болов уу гэж бодогдож байна.

**С.Ганбатаар:** Үүрийнтуяа гишүүн тайлбар өгье.

**Д.Үүрийнтуяа:** Яамнаас тодруулъя. Нүүрс химийн үйлдвэрийн талаар яг ямар агуулгаар нь тодорхойлж оруулсан юм бэ гэдгээ илүү тодорхой болгоод өгөөч.

**С.Ганбатаар:** 8 дугаар микрофонд.

**С.Сүхбат:** Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны газрын дарга Сүхбаатарын Сүхбат. Нүүрс химийн хувьд бид нар энэ Тавантолгойг түшиглэсэн үйлдвэр технологийн паркийн хүрээнд баяжуулж байгаа нүүрсийг дараагийн шатын бүтээгдэхүүн болгох гэдэг агуулгаар нүүрс хими гэж оруулсан байгаа. Мөн Дорноговь аймаг дээр баригдаж байгаа 2 байршил дээр үйлдвэр технологийн парк паркийн хүрээнд нэлээн хэдэн үйлдвэрүүд баригдаж байгаа. Энэ үйлдвэрийн нэг хэсэг болохоор нүүрсний

баяжмалаас кокс металлургийн кокс үйлдвэрлэх үйлдвэр нь бас Дорноговь аймагт яг баригдаж байгаа учраас тэр агуулгаар оруулсан байгаа.

**С.Ганбаатар:** Тодруулж асууж дууслаа. Саяын нүүрс химийн үйлдвэр гэж нэмэх гэдгээр санал хураалт явуулъя.

Үүрийнтуяа гишүүний санал 23.5 хувиар дэмжигдсэнгүй.

Ингээд болчихож байна уу? Үүрийнтуяа гишүүний санал болчихлоо. Өөр санал байгаа билүү нэг байгаа юу? Байна байна. Үүрийнтуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар дахин санал хураалгана.

Би саналыг та бүхэнд танилцуулъя. Үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 11 дэх төслийн нэрийг доор дурдсанаар өөрчлөх саналтай. Гангийн цогцолбор гэсэн ийм санал байна. Гишүүн саналаа тайлбарлана уу?

**Д.Үүрийнтуяа:** Гангийн үйлдвэр гэдгээр томъёологдсон байна лээ. Мөрийн хөтөлбөр дээр. Тэгээд гангийн үйлдвэр гэдэг бол ерөөсөө нөгөө яг ган бүтээгдэхүүн рүүгээ чиглэхээд байгаа юм. Хэрвээ бид нар гангийн цогцолбор гэвэл нөгөө ган бүтээгдэхүүнийхээ түүхий эдийн үйлдвэртэй нь хамтад нь ярих боломжтой юм болов уу гэж би харж байгаа юм. Өнөөдөр бол манай дээр төмрийн хүдэр бид нар төмрийн хүдрээ баяжуулж чадахгүй. Үндсэндээ бараг өндөр агуулгатай хүдрээ түүхийгээр нь л экспортод гаргаж байгаа шүү дээ. Одоо хаягдал төмөр гэдэг ойлголт манайд байхгүй болчихсон. Тийм болохоор бид нар яалт ч үгүй энэ олборлож байгаа төмрийн хүдрээ баяжуулж байж тэндээс гарч байгаа хорголжоороо бид нар гангийн үйлдвэрийнхээ түүхий эдийг бий болгох ёстой. Энэ нь цогцоороо цогцолбороороо ган бүтээгдэхүүн эцсийн бүтээгдэхүүн гаргах энэ цогцолбор

байдлаар хөгжих ёстой юм. Энэ агуулгаар нь бүтнээр нь оруулах нь зүйтэй юм гэсэн ийм зарчмын саналыг гаргаж энэ дээр зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байгаа юм.

Тэгэхээр хэрвээ зөвхөн гангийн үйлдвэр гээд дангаараа орчих юм бол ган бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тухай асуудал л яригдана. Түүхий эдээ хаанаас авч дараа нь ган бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх вэ? Тэгэхээр одоо бол манай дээр гангийн үйлдвэрүүд дангаараа бий шүү дээ. Тухайлах юм бол хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай хийгдсэн бэрэнгийн үйлдвэрийг нэрлэж болно. Түүхий эдгүйн улмаас төмрийн хүдрээ төмрийн баяжмалаа байхгүйгээс авч чадахгүй байгаа байгаагаас болоод үйлдвэрлэл нь бүрэн явж чадахгүй болчихсон ийм нөхцөл байдалтай.

Тэгэхээр энийгээ цогцолбор байдлаар нь хамтад нь авч үзэх нь зүйтэй байх гэсэн санал оруулж байгаа юм.

**С.Ганбаатар:** Яамны зүгээс гангийн үйлдвэр гэж оруулж ирсэн байх. Тэгээд тайлбар өгнө үү? Микрофон.

**С.Сүхбат:** Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны газрын дарга Сүхбаатарын Сүхбат. Эдийн засгийн хөгжлийн яам руу бид саналаа явуулахдаа маш тодорхой бичиж өгсөн. Өөрөөр хэлэх юм бол Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн гангийн үйлдвэрлэлийн цогцолборыг 2024-2028 онд барьж байгуулна гэж оруулсан байгаа. Энэ төсөл дээр бол яг нэр зааж өгөөгүй хэвлэгдчихсэн байгаа. Бид нар анзаарсан. Ер нь бид энэ 2014 оноос хойш Дарханы төмөрлөгийн үйлдвэрт түшиглэсэн гангийн үйлдвэр байгуулах ажлыг 10 жилийн хугацаанд ярьж байгаа. Гангийн үйлдвэртэй холбоотой асуудлаар ахиц дэвшил маш муу байгаа.

Тийм учраас энэ 4 жилийн хугацаанд Дарханыг гангийн үйлдвэр их болох тал дээр манай яам бас нэлээн нарийвчилсан судалгаа ажлууд зохион байгуулж хийхээр байгаа гэдгийг хэлье.

**С.Ганбаатар:** Ингээд тодрууллаа. Саналаа хураая. Үзэл бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 11 дэх төслийн нэрийг доор дурдсанаа өөрчлөх саналтай. Гангийн цогцолбор санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа.

Санал хураалт.

Энэ санал 52.9 хувиар дэмжигдлээ.

Дараагийн саналдаа оръё. Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл гишүүний санал ирсэн байна 13 цаг 50 минутад.

Саналын утга нь эдийн засгийн бодлогын хүрээнд 3.3.2-т боомтын шинэчлэл, тээвэр, логистик, 3.3.2.19 дээр эсхүл 3.3.2.20 гэж зүйлд зааснаар нэмж тусган Даянгийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох бүтээн байгуулалтыг эхлүүлнэ гэж тусгах гэсэн ийм саналын томъёолол өгсөн байна. Та бүхэнд уншиж танилцууллаа. Саналаа та тайлбарлах уу? Жангабыл гишүүний микрофоныг нээе.

**Х.Жангабыл:** Аливаа боомт бол Монгол Улсын болон бүс нутагтаа нийгэм эдийн засагт асар их ач холбогдолтой. Тухайлбал манай аймагт Цагааннуурын боомт ажиллаж байсан. Социализмын үед баруун 5 аймгийг бараа тэгээд бүх бүтээгдэхүүнээр хангаж байсан. Тэгэхээр их ач холбогдолтой юм. Одоо энэ Даянгийн боомтыг зураг төсөв нь бэлэн болчихсон. Хатуу хучилттай авто замаар холбочихвол асар их ач холбогдолтой. Аялал жуулчлалыг хөгжүүлэх тэгээд БНХАУ-аас бараа материал бүс нутагтаа хямд өртөгтэй татах.

Гуравдугаарт бол Даянгийн боомтоор гарсан машин маань хамгийн дөт замаар ОХУ-ыг холбох, ОХУ-ын аж үйлдвэржилтийн бүстэй холбох ийм их асар ач холбогдолтой. Тэгэхээр энэ зарчмын зөрүүтэй санал дээр санал хурааж өгнө үү гээд хүсэх байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Тулга сайд тодруулъя гэж байна. Хариулах уу? Хариулт байна.

**Б.Тулга:** Тэгэхлээр Жангабыл гишүүний зарчмын зөрөөтэй санал дээр бол манай Боомтын сэргэлтийн үндэсний хороо, Засгийн газар бас дэмжсэн байр суурьтай байгаа гэдгийг хэлье. Ер нь яг энэ найруулга дээр явахад хэд хэдэн бас явагдаж байгаа төлөвлөж байгаа тэр ч тусмаа юу гэдэг юм замын зураг төсөл нь хийгдчихсэн хэд хэдэн боомтуудын нэр бол орхигдчихсон байгаа. Жангабыл гишүүн бол энэ дээр Даянгийн боомтыг хөндөж оруулж ирж байна. Даянгийн боомт бол өөрөө Монголын байгалийн үзэсгэлэнтэй газар байдаг. Цаад хөрш зэргэлдээ улсуудад байгаа эдийн засаг аялал жуулчлалын нөхцөл байдлыг нь аваад үзэх юм бол бас их маш олон тооны жуулчид цаанаа ирдэг. Дэд бүтцийн хувьд бас онгоцны буудал дээр баригдсан нэлээн тийм хөгжилтэй газар байгаа. Тийм учраас Даянгийн боомтоор дамжуулаад аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх бүрэн ийм боломжтой боомт байгаа. Зүгээр ер нь үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт бол 3.3.2.23 заалтад бүс нутгууд хилийн боомтуудыг холбосон шинэ сэргэлтийн 5 тойрог гэдэг энэ ерөнхий агуулга дотор бол яах вэ үйл ажиллагааны хөтөлбөрт байгаа. Тэгээд гишүүн бол энийг илүү тодотгоод бусад Бичигтийн боомтыг авто замаар холбох гэдэг энэнтэй ижилхнээр Даянгийн боомтыг бас оруулж өгөөч ээ гэдэг ийм хүсэлтийг бас тавьсан байгаа.

Тийм учраас энийг дэмжээд оруулахад бол бас бүрэн бололцоотой гэж та бүхэнд бас мэдээлэл өгье өө.

**С.Ганбаатар:** Саналаа би дахиад тодруулж уншъя.

Ингээд эдийн засгийн бодлогын хүрээнд 3.3.2 боомтын шинэчлэлт, тээвэр, логистик 3.3.2.19 дээр эс үгүй бол 3.3.2.20 гэж зүйл заалт нэмж тусган Даянгийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох бүтээн байгуулалтыг эхлүүлнэ гэж тусгах, санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жангабыл, Аубакир Зулпхар гэсэн ийм 3 гишүүний санал орж ирж байгаа юм байна.

Ингээд саналын томъёоллын дэмжье гэсэн томъёоллоор та санал хураалт явуулъя.

52.9 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн саналыг хураалгая.

Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайханы санал орж ирсэн байна. 1.3.5 7 гэдэг зүйл заалт хэсэг дээр тайлбар нэмэх:

Саналын утга хөгжил гэсэн хэсэгт доорх агуулгатай 1.3.57-г нэмэх:

Дарханы арьс ширний үйлдвэр бүрэн хэмжээнд үйлдвэрийг барьж дуусгах гэсэн ийм томъёоллоор саналын томъёолол өгсөн байна. Жаргалсайхан гишүүн саналаа тайлбарлах уу? Жаргалсайхан гишүүний микрофоныг өгье.

**Д.Жаргалсайхан:** Би бас түрүүн саналаа хэлэхдээ хэлж байсан. Ер нь малчдын орлого бол маш муу байна. Тийм учраас малчдын орлогыг сайжруулах зүйл малын гаралтай түүхий эдийг боловсруулах асуудал байгаа. Тийм учраас энэ саналыг оруулж ирж байгаа. Өмнөх бас Засгийн газруудын 4 жилийн мөрийн хөтөлбөрт орж байсан. Энэ ажлууд нь

эхэлчихсэн явж байдаг ингээд дуусахгүй байж байгаа. Тийм учраас энэ ажлыг дуусгах гэдэг нэр томъёоллоор оруулж ирсэн. Энэнээс шинээр бас яг юу гэдэг юм яг энэ ажил бол бас яг бүрэн дуусах гэдгээрээ орж ирээгүй байсан юм оруулж ирж байгаа юм.

**С.Ганбаатар:** Тайлбараа өглөө. Ингээд саналаа Дарханы арьс ширний үйлдвэрийг барьж дуусгах гэдэг томъёоллоор санал хураалт.

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Би дараагийн саналыг та бүхэнд танилцуулъя. Золжаргал гишүүний санал байна. 3.3.1.15-ыг дээр нэмэх юм байна. Эдийн засгийн бодлогын хүрээнд 9 дэх төсөлд нэмэх.

Нүүрс химийн технологийг эзэмшиж, аюулгүй ажиллуулж сурах, боловсон хүчин бэлтгэх, ирээдүйн томоохон төслийн техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг баталгаажуулж бэлтгэл хангах зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулж, хийн түлш, нийлэг материал устөрөгч гарган авна гэсэн энэ саналыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгье.

Нийт гишүүдийн 58.8 хувиар санал дэмжигдлээ.

Одоо нэг зарчмын зөрүүтэй санал байгаа юм байна. Уянгаа гишүүний саналыг та бүхэнд танилцуулъя.

Эдийн засгийн бодлого гэсэн бүлгийн хүрээнд 3 эдийн засгийн бодлого гэсэн бүлэг дээр 3.3 дахь хэсэгт 3.3.42 гэдгийг нэмэх.

Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх гэж нэмэх гэсэн ийм саналын томъёоллоор зарчмын зөрүүтэй санал гаргасан байна.



Ингээд гишүүн саналаа  
тайлбарлана. Уянга гишүүний  
микрофоныг өгье.

**Б.Уянга:** Баярлалаа. Нэлээн төгсгөлд нь өгчихсөн байсан юм. Энэ нөгөө түрүүн яамдаас асуугаад байсан байгалийн хийн хоолойн төсөл яагаад хөтөлбөрт туссаагүй юм бэ гэдэг дээр энэ асуудлыг нэмэх нь зүйтэй. 2 хөрш маань ажлаа нэлээн явуулчихсан. Манайх энийг Засгийн газрын мөрийн хөтөлбөртөө оруулахгүй бол болохгүй гэдэг агуулгаар тэгээд өмнөх 4 жилд бас ороод явж байсан. Ажил нь үргэлжлээд явж байгаа учраас энийгээ оруулах нь зүйтэй юм гээд оруулж байгаа юм. Тэгээд би холбогдох мэдээллийг бас Эдийн засгийн байнгын хороо болоод ажлын хэсэгт хүргүүлнэ.

**С.Ганбаатар:** Тулга сайд тайлбар өгөх үү асуулт уу? Тулга сайд тайлбар өгөх юм байна.

**Б.Тулга:** Тийм энэ дээр бас Ерөнхий сайд ээлжит бус чуулган эхлэхэд бас орж ирж тайлбарласан санагдаж байна. Газрын тос биш газрын тос хийн хоолой дамжуулах хоолойн төсөл бол түрүүн бас яамнаас хариулж байна. Энэ дээр бол Засгийн газар бэлтгэл ажлыг хангах тал дээр бол ажлуудаа ямар нэгэн гацаагүйгээр хийгээд явж байгаа. Зүгээр яг энд нөгөө томъёолол дээр оруулахад яагаад яг энэ үйл ажиллагааны хөтөлбөрт оруулаагүй гэдэг тайлбар дээр одоо бол энэ бэлтгэл ажил хангагдсан. Зүгээр нөгөө барьж эхлүүлэх гэхлээр биднээс хамаарахгүйгээр энэ бол цэвэр ОХУ, БНХАУ-ын хооронд шийдэгдэх асуудал. Өөрөөр хэлбэл бид шийдэхгүй. Бид бэлтгэл ажил буюу гэрийн даалгавраа хийчихсэн, яг явах эсэхийг нь бол нөгөө 2 улс маань тохирч шийдсэний дараа л ажил эхлэх учраас зүгээр яг энэ үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах нь зөв үү үгүй юу гэж байгаад оруулалгүй орхисон байгаа. Тэрнээс бэлтгэл ажил хийгдсэн явагдаж байгаа.

Хэрвээ манайхаас үл хамаараад энэ 2 улс маань хоорондоо тарифаа тохирох юм уу улс төрийнх нь нөхцөл байдал юмаа тохирсон тохиолдолд Монгол Улс бол энэ дээр нээлттэй байгаа. Хэрвээ энэ дээр юу гэдэг юм эхлүүлэх гээд явчихдаг. Энэ 2 маань тохирч чадахгүй яваад байвал энэ чинь эргээд 2028 онд үнэлгээ хийгээд ирэхлээр та нар энэ ажлаа эхлээгүй байна гэдэг ийм юм орох юм байна гэдэг ийм л үндэслэлээр байхгүй болчихсон байгаа шүү. Тэгэхлээр энд бол нөгөө томъёолол хэрвээ оруулж байгаа бол зарчмын зөрүүтэй санал оруулж байгаа бол нөхцөл байдлыг бүрдүүлэх гэсэн юмаар оруулахгүй бол яг эхлүүлэх гээд орчих юм бол наадах чинь нэг тийм дараа нь үнэлж болохгүй юм болчих болов уу гэдэг ийм болгоомжлол байна. Тэрнээс бусдаар бол энэ байх ёстой тантай 100 хувь санал нэг байна. Бид энэ бүс нут нутгийн интеграцад орж энэ бүс нутагт болж байгаа энэ дэд бүтцийн юмнуудад бол Монгол Улс нэгдэж орох нь зөв өө гэдэг ийм байр суурьтай байгаа.

**С.Ганбаатар:** Уянга гишүүн нэмэлт тодруулга хийнэ.

**Б.Уянга:** Нэмээд зүйл хэлэхэд нөгөө Засгийн газраас хийх ёстой бүх зүйлүүдээ хийгээд дуусаагүй юм байна лээ. 5 под станц байгуулах ёстой юм байна л даа. Одоо энэ Оросоосоо урагшаагаа Хятад руу гарах энэ хийн хоолой дагаад 5 под станц аймгийн хүн ам суурьшил ихтэй газрууд дээр тавигдаад тэгээд хийн хоолойгоор тэр эрчим хүчийг нь хангах тийм ажлаа бид нар хийж эхлүүлэх ёстой. Тэгэхээр тэрэн дээр байж байгаарай тэр нь тэр ажлуудаа бид нар хийх ёстой байтал Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөр дээр огт тусгахгүй байж болохгүй юм. Тэгээд бид нар атомын цахилгаан станц гээд бүүр хол зүйлийг ингээд оруулаад байдаг. Тэгэхдээ яг энэ ногоон эрчим хүчний чиглэлийн энэ Оросоос ирж байгаа байгалийн хийгээсээ под станцаараа ингээд зарим суурьшлын

бүсүүдийгээ хангах эрчим хүчээр хангах энэ бололцоо нь байгаа. Бид нар тэр ажлаа хийхгүй байгаа. Тэрийгээ хийх энэ гарцыг нь бид нар заавал хөтөлбөр дээрээ суулгах ёстой тэгээд тэрнээс өмнө засаг дээр яагаад ороогүй юм? Тэгээд ажлын хэсэг нь тэр төсөл нь төслийн нэгж эд нараас нь бүгдээс нь тодруулга авсан байгаа шүү. Манай хэд ер нь их пайниктчихсан. Өнөөдөр хүртэл оросын веб сайтаар хүртэл Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр ороогүй байна энээ тэрээ гэсэн мэдээ орсон байна. Би аж үйлдвэржилтийн энэ групп дээр нь бас тавьчихъя. Тэгээд энэ мэтчилэн зүйлүүдийгээ бүгдээрээ анхаараад оруулах нь зүйтэй байх л гэсэн ийм өөрийнхөө байр суурийг нь нэмээд хэлье. Үйл ажиллагаа бид нар хийх ёстой зүйлүүдээ бол бүрэн гүйцэд хийж дуусаагүй байгаа юм байна лээ.

**С.Ганбаатар:** Тулга сайд тодруулга хэлье гэж байна.

**Б.Тулга:** Уянгаа гишүүний оруулж байгаа саналыг зарчмын хувьд дэмжиж байгаа юм, би. Тэгэхдээ нөгөө энэ нөгөө төслийг эхлүүлэх гэж тавих юм уу бэлтгэл ажлыг хангах уу гэж тавих уу гэдэг л байгаа юм. Хэрвээ энэ 2 маань эхлэхгүй байвал бид нар нэмж станц тэнд барих ямар ч тийм зарчмын хувьд юугүй шүү дээ. Тэгэхээр тэр бүх нөхцөл байдлыг томъёолол дээр л хэлээд байгаа юм. Та нөгөө эхлүүлэх гээд байна шүү дээ. Би бол илүү энэ төсөл хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх гэдэг ийм томъёолол байж болох уу л гэж байгаа юм. Тэрнээс биш үйл ажиллагааны хөтөлбөрт орсон байхад таны хэлж байгаагаар ер нь бол зөв. Нөгөө 2 талдаа бид бас хамтрахад бэлэн байна гэдэг юм харуулж байна гэсэн үг шүү дээ. Тэрэн дээр л би хэлээд байгаа шүү.

**С.Ганбаатар:** Очирбат гишүүн ээ санал нэр аваад тасалсны дараа ингээд шууд шууд орж ирэхлээр бас нөгөө хурлаа үл хүндэлсэн болчихоод байдаг. Энэ удаа

та үгээ хэлчээд үг хэлье гэсэн үү? Тийм нэр аваагүй болохлоор дараа дараагийн хурал дээр энэ бас хурлаа бид хүндлэх ёстой шүү. Ингээд саяын Уянгаа гишүүний гаргасан саналаар Байгалийн хий дамжуулах хоолойн төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх гэж нэмэх гэдэг энэ саналын томъёоллоор санал хураалт.

Энэ санал 41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ингээд тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байна уу? Мөнхбаясгалан гишүүнээр тасаллаа Очирбат гишүүнээр тасаллаа. Жаргалсайхан гишүүний нэр бас орсон шүү. Мөнхбаясгалан гишүүнээр эхэлж байгаа. Ингээд Мөнхбаясгалан гишүүн асуулт асууж саналаа хэлнэ үү.

**Л.Мөнхбаясгалан:** Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 14 том мега төсөл байгаа.

Энэнтэй холбогдуулж асуулт асуух гэсэн юм. Газрын тос боловсруулах үйлдвэр их удлаа. Энэ дээр би өнөөдөр Ерөнхий сайдад асуулга тавьсан байгаа. Холбогдох мэдээллийг өгөөч ээ гэж хүсэж байна. Энэ төсөл яагаад өдий болтол ингэж удааширалтай яваад байдаг юм бэ? Газрын тос боловсруулах үйлдвэр бүрд яг авсан ашиглалтын лиценз олборлолт бол ашиглалтын лиценз, хайгуул болон ашиглалтын лиценз байдаггүй юм байна. Мөн гадаад компаниуд нэлээд олон юун дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх туслан гүйцэтгэгч компаниудаар ажилладаг юм байна. Энд хэчнээн компани хэчнээн юутай ажилладаг юм? Эдийн эдийн засаг нөгөө тооцоо нь хэчнээн юугаар хэчнээн гадаадын компани ажилладаг, туслан

гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа. Тэгээд одоо лиценз байдаг уу байдаггүй юу гэдэг дээр 2 асуулт асууя. Тавантолгойн дулааны цахилгаан станц дээр бас дахиад асуулт асууя. Энэ дулааны цахилгаан станц лав миний мэдэж байгаагаар 4 жил баригдсангүй ээ. Дээр тайлбар хийсэн энэ нь шүүх дээр яваад гацсан гэсэн байсан. Энэ яг үнэн юм уу? Ямар учраас шүүх дээр очоод гацчихсан байгаа юм бэ? Яагаад явдаггүй юм бэ? Эрдэнэбүрэний усан цахилгаан станц дээр очиж үзсэн. Энэ бол дөнгөж эхэлж байсан. Одоо төслийн явц ямар шатдаа явж байгаа вэ? 3 асуулт асуулаа.

**С.Ганбаатар:** Яамнаас хариулт өгөх үү? Туваан сайд хариулт өгөх юм байна.

**Ц.Туваан:** Газрын тос боловсруулах үйлдвэр яг Эрдэнэс Монгол нэгдэл дотор байгаа. ЗГХЭГ-ын эрхлэх асуудлын хүрээн дотор явж байгаа. Тэгэхдээ манай яам бас юу гэдэг юм бодлогын хувьд оролцоод ингээд явж байгаа. Лицензийн хувьд бол лиценз байхгүй. Тэгэхдээ бид бүхэн Давст 31 гэдэг газрын тосны талбай зарлахаар Засгийн газрын хуралдаанд ирэх 7 хоногт оруулахаар ингээд саналаа аваад явж байгаа. Тэгэхээр энэ асуудал нь засгаар тун удахгүй орно гэсэн үг. Асуудал нь юундаа байна вэ гэхлээр энэ нэг 2, 3 асуудал байгаа тэр нь юу гэхлээр одоо Энэтхэгийн 1 тэрбум 200 сая долларын зээлийн асуудал байгаа. Засгийн газар хоорондын. Тэгээд энэ зээл нь бас юу гэдэг юм хүрэхгүй. 400 орчим 423 сая доллароор энийг нэмэгдүүлэх ийм хүсэлтийг тавиад ийм шийдвэрийг шийдвэрлэж өгөөч гээд Энэтхэгийн Засгийн газарт бас тавьчихсан байгаа. Тэгээд энэ асуудал дээр бол 1 жил 6 сар орчим Энэтхэгийн талаас бас хариу өгөөгүй ийм асуудал байгаа.

Дээрээс нь бас манай энэ төслийн ЕРС 1, 2, 3, 4 гээд ийм 4 багц явж байгаа. Энэний нэгдүгээрх нь бол хэрэгжиж

дуусаад улсын комисс хүлээж авах шатдаа явж байгаа. 4 дүгээр багцын хүрээнд орох зардлаа бид бүхэн тэр 1.2 сая долларынхоо, тэрбум долларынхоо хүрээнд оруулаад багтаагаад ингээд бас асуудал явж байгаа. Мөн нэг асуудал нь бол энэ зээл аваад явдаг өөрөөр хэлбэл энэ үйлдвэр маань. Тэгэхээр энэ зээл дээрээ бас зээлийн хүү нэлээн өндөр байдаг.

Дээрээс нь зээлийн барьцааны асуудал гэсэн ийм асуудлууд нэлээн яригддаг. Тэгэхээр манай талд дотоод асуудал нэлээн байгаа. Дээрээс нь энэ ашиглалт одоо газрын тосны шугам тэнд ажиллах ажилчдын орон сууц эрчим хүч дамжуулах шугам зам энэ тэр гээд энэ асуудлуудын ашиглалттай холбоотой ашиглалт арчилгаатай холбоотой зардлууд нь бол энд тэнд тусгагдаагүй ингээд шийдвэрлэгдээгүй яваад байгаа юм. Тэгэхээр энийг бид нар бас ирэх жилийн төсөв дээр тавьж шийдвэрлүүлэх гэх мэт ийм асуудлууд байгаа. Тэр хэдэн компани гэдэг дээр манайхан Анхбаяр тодорхой тоо хэлчих.

**С.Ганбаатар:** 5 дугаар микрофон нээе.

**Б.Анхбаяр:** Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны газрын тосны бодлогын газрын дарга Анхбаяр. Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Яагаад ингээд гацаад явахгүй байгаад байгаа юм бэ гэдэг асуултыг түрүүн эхлээд асуусан. Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл маань анх 2017 онд яг төсөл хэлбэрээр бол хэрэгжиж эхэлсэн. Түүнээс хойш ер нь 2019 онд бол Ковид-19 цар тахлын үед бол бас нэлээн хугацаа алдсан ийм асуудлууд байгаа. Энэтхэгийн талтай бол бид нар энэ асуудлуудыг хамтарсан байдлаар нөхөх стратеги төлөвлөгөө энэ тэр боловсруулаад явж байгаа. Одоогийн байдлаар газрын тос боловсруулах үйлдвэр дээр нийт ЕРС 4 гэрээ хэрэгжиж байгаа. 4 гэрээний хүрээнд бол дандаа

өөрсдийн Энэтхэгийн талаас туслан гүйцэтгэгч нарыг оруулж ирж ажиллаж байгаа. 2024 оны байдлаар бол талбай дээр нийт одоогийн байдлаар нэг 600 орчим гадаадын иргэд ажиллаж байна. Энэ хугацаанд дээрээс нь Монголын бас туслан гүйцэтгэгч компаниуд бас давхар ажиллаад явж байгаа.

Тэгэхээр танд яг бүүр нарийн тоонуудыг нь албан бичгээр цаашид хүргүүлье.

**С.Ганбаатар:** ЕРС гэж хэлсэн дээрээс зүгээр түлхүүр гардуулах л нөхцөл шүү дээ. Тэгээд наадуул чинь түлхүүрээ гардуулж өгөхгүй л мөнгө нэхээд суугаад байгаа юм шүү дээ. Тэгээд л бид аманд нь унаад л мөнгийг нь нэмж өгөөд яваад байгаа юм гэдгийг зүгээр даширамд хэлчхээд энэ 2 дахь асуудал нь Очирбат гишүүн, Жаргалсайхан гишүүд маань бас анхаараарай. Юу гэвэл энэ Ерөнхий сайд Оюун-Эрдэнэд энэ үнэлгээний шалгуур үзүүлэлтээ болон хүрэх түвшинээ тодорхой болгоорой гэсэн ийм дөрөвхөн заалттай энэ тогтоолын төсөл шүү. Тэрэнтэйгээ уялдуулж та бүхэн маань асуулт асуугаарай.

3 дахь тогтоолын хэсэг бол нэр томъёоны асуудал байгаа.

4 дэх нь зөвхөн хугацаа. Хэзээ энэ хэрэгжих юм бэ гэдэг ийм 3 хүрээнд асуулт асуух юм байна гэж би ойлгож байна. Ингээд Очирбат гишүүний микрофоныг нээе.

**Г.Очирбат:** Дарга товчхон яриарай гэж байна шүү дээ. Асуулт давхацчихсан хариултаа сайдаас сайхан авчихлаа. Баярлалаа. Бүгдэд нь амжилт хүсье.

**С.Ганбаатар:** Жаргалсайхан гишүүн.

**Д.Жаргалсайхан:** Энэ 4 шинжилгээ хийх. Дээрээс нь хүрэх

түвшинд хяналт тавих гээд үндсэндээ Монгол Улсын Засгийн газрын энэ үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр юуг харж байна вэ гэхээр экспортод гаргаж байгаа бараа бүтээгдэхүүнээ боловсруулж гаргах л асуудал яригдаж байгаа юм. Тэгээд дараагийн асуудал бас энэ томоохон аж үйлдвэр энэ ордуудыг бий болгох зах зээлээ тэлэх гэсэн тэгээд энэ дээр Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумд, Эрдэнэ Монгол гээд томоохон ордууд нээгдэж байна. Үйл ажиллагаанууд явж байна. Энэн дээр яаж? байгалийг хамгаалах байгаль орчны нарийвчилсан үнэлгээг биелүүлэх дээр ямар зорилт тавьж байна вэ? Одоо бидний Цогтцэций, Ханбогд энэ нүүрс Оюу Толгой, Тавантолгой явж байгаа бүс нутаг үндсэндээ байгалийн гамшиг болсон шүү дээ. Энэ гамшигийг Баянхонгор аймгийн энэ бүс нутаг бий болгохгүй тал дээр та бүхэн маань ямар бас байдлаар төлөвлөж ажиллаж байгаа вэ? Энэ дээр ямар зүйлийг анхаарч ажиллах ёстой вэ гэдэг дээр бас нэг дэх асуулт.

2-т нь Дарханы арьс ширний үйлдвэр хэд хэдэн жил бас ингээд үйл ажиллагааны хөтөлбөрт ороод томоохон ажлууд буюу хөрөнгө оруулалтууд хийгдсэн. Энэ өнөөдөр яагаад ингээд зогсчихов оо? Энэнээс яагаад ингээд үр дүн гэдэг юм гарахгүй байна вэ гэсэн ийм 2 дахь асуудал байна.

**С.Ганбаатар:** Тодруулах нь хэдэн номерын микрофон? Туваан сайд хариулах юм байна.

**Ц.Туваан:** Жаргалсайхан гишүүний асуултад хариулья.

Мэдээж энэ уул уурхайн асуудал бол байгаль орчинтой салшгүй холбоотой. Тэгэхээр бид бүхэн бол энэ яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам бол бодлогынхоо хүрээнд хариуцлагатай уулын уурхай гэдэг энэ чиглэл рүү ажиллаж байгаа. Тэгэхээр энэ дотор нь юу гэж ойлгогдож байгаа вэ гэхлээр



тухайн, орон нутаг, тэнд амьдран сууж байгаа иргэд, мөн компани гээд энэ асуудлууд нь бүгдээрээ яг юу гэдэг юм харилцан ашигтай байдлаар байгаль орчиндоо ч гэсэн ээлтэй сайн технологи ашиглах энэ тэр гээд яг иймэрхүү байдлаар бид нар төлөвлөж байгаа.

Тэгэхээр мэдээж улс орны хувьд бол орлого чухал. Монголчуудын хувьд бас энэ эдийн засгийн асуудал маш чухал. Тэгэхээр бид нар бол энэ дээр уул уурхайгаа ашиглаж явахаас өөр арга байхгүй. Тэгэхдээ харин тийм хариуцлагатай уул уурхайн түвшинд л асуудлаа бүрэн шийдэж явах учиртай. Тэгэхээр байгаль орчин дээр илүү анхаарал тавьж байгаа гэж танд хэлье.

**С.Ганбаатар:** Гишүүдээс 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж тайлбар өглөө. Өөр асуулт байгаа юм уу? 2 асуулт байгаа юу? Өөр дараагийн асуултад хэн хариулах юм? Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээж өгье.

**Б.Жамуха:** Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя.

Дархан арьс ширний цогцолборын гүйцэтгэх захирал Жамуха байна. Тэгээд энэ таны эхний асуулт болох энэ төсөв дээр мөнгө тавигдаад гэдэг дээр бол яг 2024 оноос эхлээд улсын төсөв дээр яг мөнгө тавигдаж эхэлсэн байгаа. Өмнө нь энэ төслийг Италийн Засгийн газраас хөнгөлөлттэй зээлээр явах хэлбэрээр төлөвлөж явж байсан. Хөнгөлөлттэй зээл нь бол бүтээгүй байгаа. Тэгээд бид нар яагаад энэ ажил гацсан бэ гэвэл урьд нь Дархан дээр хувийн хэвшилүүд бүтээн байгуулалтын ажлаа хийгээд эхэлсэн байсан. 2022 оноос бол төр бас энэ ажлыг хурдатгах үүднээс хажууд нь зэрэгцээж бас ажлаа хийнэ гэсэн тэгээд энэ нь шүүхийн маргаанаар явагдаж бас төр хувийн хэвшлийн хийсэн бүтээн байгуулалтыг төрийн байгууллагад шилжүүлэх замаар Хөгжлийн банктай

тохиролцож авна гэдэг ажил явагдаж байгаад бол 2023 оноос энэ ажил маань явагдаад 3 яамны хамтарсан ажлын хэсэг гараад явж байгаад 2024 оны 2 сард Хөгжлийн банкнаасаа хувийн хэвшилтэй тохиролцож болохгүй нь ээ гэдэг бичгийг Хөдөө аж ахуйн яаманд хандаж илгээсэн байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор 2024 онд 4 сард Засгийн газрын хурлаар энэ асуудлаа оруулаад энэ асуудлыг явуулъя гэхэд бол сонгуулийн дараа хэдүүлээ энэ асуудлыг эргэж нэг харъя гэдэг байр суурьтайгаар хойшуулсан байгаа. Одоогийн байр суурь бол энэ асуудлыг өмнө нь явж байсан хэлбэрээр нь улсын төсөвт хөрөнгийг нь шингээж явна гэдэг төлөвлөлттэй явж байгаа.

**С.Ганбаатар:** Жаргалсайхан гишүүн санал хэлье.

**Д.Жаргалсайхан:** Би бас сайдаас ийм асуулт асууж байгаа нь яагаад вэ гэхээр энэ бүс нутгийн яг Оюу Толгой, Тавантолгойн, Ханбогд Цогтүцэций шиг битгий болчхоосой л гэж ингэж хэлж байгаа юм. Уул уурхай энэ олборлолтууд бүгдээрээ яваад экспортлолт хийгээд ингээд баахан л машин тэрэг ингээд газар нутаг тоос шороо бүүр усгүй болчихсон. Гэтэл яг Баянхонгорын яг тэр говь бүс нутаг яг ийм хэмжээнд хүрчих вий. Энд хүрэхгүйн тулд бид нар эхлээд дэд бүтцээ барих ёстой л гэж байгаа юм. Хэдхэн хоногийн өмнө бас бид нарт гомдол ирж байна. Ганбаатар гишүүн бас энийг мэдэж байгаа. Том оврын машинууд яг говийн бүсийн энэ замууд л үнэхээр даахгүй цөм үсрээд л орчихно. Тэгээд л нөгөөдхийг татаж гаргах гэж бөөн бас нэг зам эвдрээд л тэгээд тэр замаар дахиад машин явах үндэс байхгүй тал дүүрэн зам болж байгаа. Тэгээд энэ бүс нутаг үндсэндээ ингээд эко систем нь үнэхээр гамшиг болоод тэгээд ард иргэд маань энийг эсэргүүцээд өргөх бас ингээд бичиг жагсаал цуглаан эсэргүүцэл ингээд ийм хэмжээнд хүрсэн.

Тэгэхээр энэ дэд бүтцээ тавьж байж энэ төслүүдийг эхлүүлэх дээр анхаараач ээ. Энэ бүс нутаг бол Их говийн дархан цаазат газар шүү дээ. Яг ийм газар байгаа. Тэгэхээр энэ тал дээр анхаарч өгөөрэй гэсэн ийм бодол байна.

Дээрээс нь 2 дахь асуудал дээрээ бас хэлэх гэсэн юм. Энэ малын гаралтай түүхий эдийг боловсруулах дээр энэ бүс нутгуудад гээд ингээд орчихсон байгаа юм. Яагаад бид нар энийг ингэж нэг дор барих гээд байгаа вэ гэхээр нэг их төмөр замтай газар юм. Дээрээс нь бидний энэ малын түүхий эд гэдэг чинь хэдэн саяараа гарч байгаа юм. Хэдэн саяараа гарч байгаа учраас өрсөлдөх чадварын хувьд нэг дор энэ их хэмжээгээр үйлдвэрлэх юм бол нэгж бүтээгдэхүүний төлбөр бага гарах гээд байгаа юм.

Тийм учраас Дархан гэдгийг сонгосон. Тэгэхээр энэ бүс нутгууд бүр дээр нөгөө бас малын гаралтай түүхий эдийн үйлдвэр барина гээд энэ хөтөлбөр дээр орчихсон байж байгаа. Энэ бол үгүй шүү. Тэгээд энэ талаа бас манай энэ мэргэжлийн хүмүүс бол барьж байгаа байх гэж үнэхээр бодож байна. Ийм саналтай байна.

**С.Ганбаатар:** Уянга гишүүн санал хэлье. Тэгээд саналаа ингээд тасалчхаж байгаа шүү. Түрүүн тасалчихсан үг хэлэх санал.

**Б.Уянга:** 2 зүйлийг л хэлье. Дарга нөгөө ирц 22-оос 17. Энд бол 17 хүн байхгүй байна шүү дээ. Тэгээд түрүүний нөгөө олон санал унадаг шиг тэгээд л яг энд байгаа хүмүүс нь зөвшөөрлөө зөвшөөрлөө гэхэд тэгээд тогтоол энэ 2 дугаар хавсралт унах вий.

Хоёр дахь нь болохоороо Жаргалсайхан гишүүнд хандаад зүгээр яах вэ нөгөө нэг зүйлийг хэлэх ёстой байх.

Өмнөговь аймгийн зарим суманд гамшиг боллоо. Байгаль орчны асуудал нь

ингэлээ энэ бол уурхайтай холбоотой гээд. Ингээд та мэдээж хэлэх эрх нь байгаа. Гэхдээ бүгдээрээ нэг жаахан үндэслэлтэй яг энэ аж үйлдвэржилттэйгээ дэмжээд явуулах ёстой энэ Байнгын хороон дээрээ яг судалгаа нь байгаа бол яг гамшиг гэдгээ юугаар тодорхойлж байгаа юм. Тэгээд өнөөдөр Байгаль орчны байнгын хороон дээр яг энэ агуулгаараа яригдахгүй л байдаг. Тэгээд дараа дараагийн төслүүдийг бид нар нээх л ёстой. Тэгээд сайд нь өөрөө хариуцлагатайгаар аваад явна гээд хэлээд энэнээс илүү өөр яаж тайлбарлах билээ дээ. Тэгэхээр энэ дээрээ бүгдээрээ дараа дараа зүгээр Улсын Их Хурлын тухай хуулийн нөгөө гишүүдийн эрх үүрэг дээр заавал мэдээллээ үндэслэлтэй ярих ёстой гэхчхэн байгаа юмыг чинь тэрэн дээрээ бас нэг анхаараад явахыг хүсэж байна. Тэгээд ямар нэгэн байдлаар таны үг нэлээн жинтэй тусна.

Тэгэхээр нөгөө яг үзэж байгаа хүмүүс маань ингээд л гамшиг болчихдог юм байна гэж бодох вий. Тэгээд тэрэн дээрээ хаа хаанаа анхаараад явах ёстой байх. Тэгээд өөрийнхөө хувьд цааш цаашидаа оруулах бүх юм болгон дээрээ л үндэслэлтэй л ярина. Тэгээд энэ мэтчилэн бүгд л дор бүрнээ анхаараад явах нь зүйтэй байх. Нэг ийм л саналтай байна.

**С.Ганбаатар:** Саналыг сонслоо. Гишүүд маань бүүр дискурс хийгээд яваад эхэллээ. Тэгэхээр тогтоолын төслийн 2 дугаар зүйлийг энэ дээр бол хэлэлцэнэ санал хураахгүй. Бичихээр бол зарчмын зөрүүтэй санал ирээгүй учраас шууд хэлэлцэж дууслаа гэдгээр явах юм байна лээ шүү. Ингээд гишүүдээс санал ирээгүй учраас гишүүд асуулт асууж, тодруулж, үг хэлж дууслаа.

Тогтоолын төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

3 дугаар зүйл рүүгээ орно.

3 дугаар зүйл дээр та нар маань 3 дугаар зүйлийнхээ асуудалтай холбогдуулж асуулт асууж үг хэлбэл мөн сайн байна. Тэр нь юу вэ гэвэл энэ тогтоолын төсөл гээд урьд нь тараагдсан байгаа. Нэр томъёотой холбоотой ийм нэг хуудас л юм байгаа шүү. Нэр томъёотой, энэнтэй холбогдуулж асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Асуулт асуух гишүүд алга байна. Санал гаргах санал гаргах гишүүд байна уу? Байхгүй байна.

Ингээд тогтоолын төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Тогтоолын төслийн 4 дүгээр зүйл.

Та бүхэнд тараагдаагүй бол би уншъя. Энэ 4 дүгээр зүйлд нь энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн энэ зүйлийн талаар л бид асуулт асууж бас тайлбар авах юм байна. Энэ тараагдаагүй гэж үндэсгүй. Нөгөө түрүүн та нар нөгөө тогтоолын төслийн нэг гээд нөгөө хавсралт нь та нар дээр оччихсон байгаа юм чинь өмнөх тогтоолын төсөл нь зайлиггүй очсон байх ёстой шүү. Улсын Их Хурлын хөтөлбөр батлагдах тухай тогтоолын төсөл шүү.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын гэж орж ирсэн байгаа. Ингээд тогтоолын төслийн 4 дэх зүйл дээр та бүхэн асуулт асууж тодруулах гишүүд байна уу? Алга байна. Санал хэлэх гишүүд байна уу? Санал байна уу? Үүрийнтуяа гишүүн санал хэлнэ.

**Д.Үүрийнтуяа:** Тэгэхээр 1 талаасаа тогтоолтой холбоотой нөгөө талаасаа бас дэгтэй холбоотой надад тодруулах санал байгаад байна л даа. Тодруулах зүйл байна, санал байна. Ажлын албанаас бас асуумаар байна. Дэгийн тухай хуулийн 39-ийн би андуураагүй бол 14 шиг санах юм.

Яаралтай горимоор хэлэлцсэнээс бусад тохиолдолд бид нар зарчмын зөрүүтэй саналаа хугацаа зааж өгөх ёстой. Яаралтай горимоор хэлэлцэж байгаа үед бид нар хурлынхаа явцад тухайн асуудлаар санал хураагаагүй байх цаг хугацаанд нь зарчмын зөрөөтэй саналаа өгөх эрх нь гишүүнд нээлттэй байгаа гэж би ойлгож байгаа шүү дээ. Тэгээд түрүүн би тэр 10 дахь асуудал дээр ерөнхийдөө бол яах вэ тэр 10 дахь төслийн нэр дээр миний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэн. Тэр нь зөвхөн төслийн нэртэй холбоотой байсан юм. Ард нь яг тайлбар хэсэг дээр буюу хүрэх үр дүн хэсэг дээр Очирбат гишүүн бас тодорхой саналууд хэлсэн. Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам маань өөрөө яг энэ томъёоллоор анх саналаа оруулсан. Энэ томъёоллоороо байх нь зүйтэй байна гэдэг дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад ажлын алба хүлээж авсангүй л дээ.

Тэгэхээр бид нар энэ дэгээ яаралтай горимоор хэлэлцэж байгаа үед санал хураахаас өмнө гишүүн ер нь санал гаргах эрхтэй юм уу эрхгүй юм уу цаашидаа энийгээ бас тодорхой болгочихмоор байна. Мэдээж төлөвлөгөөт хэлэлцэж байгаа яаралтай горимоор хэлэлцэж байгаагаас бусад үед бид нар 2 хоногийн өмнө зарчмын зөрүүтэй саналаа өгөх ёстой. Тэгээд хэрвээ болно гэвэл би бас яг энэ тогтоолын төслийг эцэслээд батлахаас өмнө саналаа өгчихмөөр байна. Болохгүй гэвэл надад бас үндэслэлийг нь тодорхой хэлээд тайлбарлаад өгчих.

**С.Ганбаатар:** Улсын Их Хурлын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Агар-Эрдэнэ тайлбар өгнө.

**Г.Агар-Эрдэнэ:** Гишүүний асуултад хариулъя. Сая хэлсэнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.14-д заасан байгаа. Тухайн төслийг яаралтай

горимоор хэлэлцэж байгаагаас бусад тохиолдолд холбогдох Байнгын хороо анхны хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр гишүүдийн зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хүлээж авах боломжтой байгаа. Энэ хөтөлбөрийн төслийг бол яаралтай горимоор хэлэлцэж байгаа учраас гишүүд бол холбогдох Байнгын хорооны хуралдаан дээрээ зарчмын зөрүүтэй санал байвал гаргаад хураалгах боломжтой. Гэхдээ бол дэгийн хуулийн дагуу зүйл бүрээр хэлэлцэж байгаа үед тухайн зүйлтэй холбоотой асуудлаар нь саналаа гаргаад ингээд явна гэсэн үг.

**С.Ганбаатар:** Үүрийнтуяа гишүүн тодруулж байна, тодруулъя.

**Д.Үүрийнтуяа:** Яг тухайн асуудлыг хэлэлцэж байх явцад санал хураахаас өмнө би саналаа өгсөн юм л даа.

**С.Ганбаатар:** Хариулах юм уу? Агар-Эрдэнэ дарга. Агар-Эрдэнэ даргын микрофоныг нээе.

**Д.Үүрийнтуяа:** Одоо тэгэхээр бид нар яг санал хэлэх боломж байхгүй учраас би санал хэлэх эрхээ авч байгаад хэлж байна. Тийм сая бол төслийн хэлэлцүүлэг дэгийнхээ хуулийн дагуу явагдаад 4 дүгээр зүйл дээр гишүүдийн саналыг авлаа шүү дээ. Тэгэхээр танд санал байсан бро 1 дүгээр зүйл дээр ямар нэгэн санал байсан 1 дүгээр зүйл буюу энэ тогтоолын төслийн 1 дүгээр зүйл чинь өөрөө 1, 2 дугаар хавсралттай байгаа шүү дээ. Тэр тухайн хавсралтууд дээр ямар нэгэн санал байсан яг тэр үедээ саналаа өгөх боломжтой байсан гэсэн үг.

**С.Ганбаатар:** Үүрийнтуяа гишүүн микрофонд хэлэх үү? Тийм Үүрийнтуяа гишүүн тайлбар өгье.

**Д.Үүрийнтуяа:** Тогтоолын төслийг одоо энэ бүтнээр нь хамгийн сүүлийн заалт хэлэлцэж байгаа. Тэгээд энэ хамгийн сүүлийн хэлэлцэж байгаа

заалт дээр яг энэ томъёолол дээрээ бол санал алга байна дэмжиж байна. Яг дэгтэй холбоотой нэгэнт бид нар Байнгын хороо халуун тогоон дотроо юмаа ярих ёстой байх цаашидаа. Ер нь бол яг тэр тухайн асуудал дээр тухайн хэлэлцэж байгаа асуудал дээр яаралтай горимоор хэлэлцэж байгаа үед тухайн хэлэлцэж байгаа асуудлыг санал хураахаас өмнө бол гишүүн саналаа өгөх эрхтэй. Тэгээд тэр саналаа өгч байхад тухайн үед нь аваагүй ингээд хаачихаар эргээд надад санал хэлэх эрх үүсэхгүй болчихож байгаа юм л даа. Саналаа хэлэх боломжгүй болчихож байгаа юм. Тэгэхээр та бүхэн маань бас энэ гишүүдийн санал хэлэх, үг хэлэх эрхийг нь хангаж ажиллаарай гэдгийг бас ажлын албанд хэлмээр байна.

**С.Ганбаатар:** Ингээд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Ингээд дараагийн хэлэлцэх асуудалдаа цөмөөрөө орцгооё. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн манайхаас Төрийн байгуулалтын байнгын хороонд хэн байгаа билээ? Дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан ТББХ-ны хуралдаанд танилцуулна уу. Ингээд танилцуулах юм байна.

16.05 цагт

Дараагийн асуудал. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.



*Ингээд ажлын хэсгээ танилцуулна. Шинээр байгаа биз дээ хуучин нь юм уу шинээр байгаа байх. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцох ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.*

*Ажлын хэсгийг Байнгын хорооныхон уриарай. Нөгөө хүмүүс маань хаана байна? Сангийн сайд Бжавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Туваан, ХХААХҮ-ийн сайд Ж.Энхбаяр, Монгол улсын ерөнхий аудитор Загджав, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Магнайсүрэн гэсэн ийм бүрэлдэхүүн байна. Энхбаяр сайдыг урья. Жавхлан сайдыг урья. Ерөнхий аудитор Загджавыг урья.*

*Жавхлан сайд танилцуулгаа хийсний дараа аудитынхан бас танилцуулах учиртай юм байна шүү. Ингээд Жавхлан сайдыг хүлээж байна. Бас Байнгын хороодын хуралдаанууд дандаа давхцаж байгаа учраас ингээд ирж байгаа байх. Бусад Байнгын хороодууд давхцаж байгаа учраас бас ер нь явуулж байсан нь дээр байх.*

*Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцох ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.*

*Туваан сайд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Магнайсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл-нийцлийн Аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Мөнхцацрал Аудитын менежер.*

*Сангийн сайд Б.Жавхлан ирсэн байгаа. Энхтуяа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Эдийн засгийн хөгжлийн яамнаас О.Мөнхтөр Хөрөнгө оруулалтын*

*бодлогын газрын Төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Санжаадорж Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга. Санжаадорж дарга ирчихсэн байгаа. Золбоо Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга, Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Батмөнх Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга ирчихсэн байна. Ичинноров Төсвийн орлогын хэлтсийн дарга, Ганзориг Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Отгонцэцэг Санхүүгийн хэлтсийн дарга Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны. Батгэрэл, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын зөвлөх, Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Идэрцогт Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Амгалан Ерөнхий санхүүч, Гэрэлзаяа ЖДҮ-лэлийн газрын Бодлого зохицуулалтын газрын дарга, Цэнд-Аюуш Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн, Жамуха Дархан Арьс ширний бүтээн байгуулалт төрийн өмчит хувьцаат компанийн захирал.*

*Ингээд та бүхэнд ажлын хэсгийг танилцууллаа.*

*Сангийн сайд Жавхлан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг та бүхэнд танилцуулна.*

*Ингээд Жавхлан сайдыг микрофон дээр урьж байна.*

**Б.Жавхлан:** Баярлалаа.

*Эрхэм байнгын хороон дарга эрхэм гишүүд ээ,*

*Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруу хуралдах тухай Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль,*



тогтоомжийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна. Хурдтай хөгжлийн төсөл хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэсэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа.

Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт тулгамдаж буй асуудлыг шийдэх эдийн засгийн өсөлтийг 5-6 ба түүнээс дээш хувь инфляцыг нэг оронтой тоонд зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх хурдтай зоригтой эрс шийдвэрүүдийг гаргаж шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна. Алсын хараа 2050 Шинэ сэргэлтийн бодлого Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна.

Үүнд:

Нэгдүгээрт бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Нийслэлийн Их, бага тойруу дахь төрийн их мэдлийн хэт төвлөрлийг задалж өөдөө тэмүүлэх Монгол буюу Говь Монголиа, Ган татлагат гүүр, Хөшигийн хөндийн туннел, Хөшигийн хөндийд төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбуулж шинэ сэргэлтийн 5 тойрог авто замын төсөл, шинэ Хархорум төсөл, Шинэ зуун мод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ зураг төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

Хоёрдугаарт гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжиж буй бүсчилсэн

хөгжил шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээний ашиглалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотголд тусгалаа.

Гуравдугаарт 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж либералчлах. Хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх шилжилтийн үеийн зардлыг тусгалаа.

Дөрөвдүгээрт Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль тогтоолын төслүүд батлагдсан.

Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг нь төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон, мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийж байна.

Тавдугаарт эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон. Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд жилд эх үүсвэр төвлөрүүлэх хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн

сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Ганбаатар:** Жавхлан сайдад баярлалаа.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав та бүхэнд танилцуулна.

**Д.Загджав:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдаж Засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж улс төрийн 3 намаас хурдтай хөгжлийн төлөөх зорилтот гэрээ байгуулж эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.4-д заасан төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн зарагчдын төсөвт 417.7 тэрбум төгрөгийн өөрчлөлт орсон байна. Танилцуулж дууслаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**С.Ганбаатар:** Загджав Ерөнхий аудитор баярлалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төслийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд бас хүргүүлсэн байгаа.

Ингээд хууль санаачлагчаас болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ өгнө үү? Уянга гишүүнийх орлоо. Ингээд Б.Уянга гишүүнээр нэрсийг тасалж байна.

Жаргалсайхан гишүүн асуултаа асууна уу.

**Д.Жаргалсайхан:** Энэ төсвийн тодотгол дээр орж ирсэн байгаа энэ хоршоо, хүүгийн татаас гээд мөн дээрээс нь үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал

гээд. Энэ 2 дээр тайлбар авах гэсэн юм, нэг дэх асуудал.

Хоёрт нь болохоор энэ үйлчилгээний төлбөр хураамж гээд энэ бас яг юуны зардал. Энэ дээр яг тодорхой тайлбарууд өгөөч ээ гэсэн ийм 2 саналтай байна.

**С.Ганбаатар:** Сангийн яамнаас асууж байна гэж ойлголоо. Санжаадорж дарга хариулна микрофон 8.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Төсвийн тодотголтой холбоотойгоор бол ХХААХҮ-ийн сайдын багцад бол нийтдээ 123 тэрбум төгрөг бол нэмэгдэхээр орж ирсэн байгаа. Энд бол 3 зардал хамаарч байгаа.

Нэгдүгээрт бол саяын зудтай холбоотойгоор малчдын авчихсан байсан хэрэглээний зээлийг үндсэн төлбөрийнх нь хүүгийн хамт хойшлуулахтай холбоотойгоор тэр хүүгийн зардал гарч ирж байгаа. Үүссэн хүүгийн зардлыг төрөөс хариуцах ийм зардал.

Хоёр дахь нь бол таны асууж байгаа хоршооны хүүгийн зардал. Одоо бол малчид бол МАА-гаа идэвхжүүлэх зорилгоор худаг ухах, эсвэл өвөлжөө нэмэх, эсвэл малын бэлчээрээ сайжруулах тэжээлээ өөрсдөө тарихад бол зориулж зээл авахаар арилжааны банкнаас 20 орчим хувийн хүүтэй зээл аваад байгаа. Нөгөө талдаа бол энэ маань өөрөө баталгаа гаргах гэхээр баталгаа гаргаж чадахгүй болчихоод байгаа юм. Өөрөөр хэлбэл малчдад барьцаа нь бол өөрөө бол малаа барьцаалъя гэхээр тэр нь бол тийм өндөр барьцаанд очиж чадахгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ батлан даалтын сангаар дамжуулаад барьцааг нь бол хангаад 2 дугаарт бол 20 орчим хувийн хүүг нь 6 хувь хүртэл бууруулаад ингээд

гарч ирж байгаа зөрөөг нь улсын төсвөөс нөхөн төлөөд ингээд малчдыг дэмжсэн ийм хоршооны зээлийн асуудал орж ирж байгаа юм.

Гурав дахь нь бол Цагаан алт хөтөлбөртэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан энэ хөтөлбөртэй холбоотойгоор бол 23 тэрбум төгрөг бол ингээд туссан байгаа. Хүүгийн үйлчилгээний зардал гэж түрүүн асуух шиг боллоо. Би хэрвээ буруу ойлгоогүй бол. Сангийн сайдын багц дээр бол Монгол Улсын нийт авсан зээлийн хүүгийн төлбөр бол тусгагдаж явдаг. Энэ маань бол өөрөө тухайн нөгөө ОУБ-аас ямар одоо хөгжлийн төслүүд авсан байна. Түүнтэй холбоотойгоор хүүгийн зардлууд тусаж явдаг байгаа. Тэр дагуугаа тооцоолсон ийм зардал бол засаж явдаг. Энэ нь бол өөрөө бол цаашаа хүү авсан газрууд руугаа буцаагаад явдаг ийм зардал байгаа.

**С.Ганбаатар:** Уянга гишүүний микрофоныг өгье.

**Б.Уянга:** Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай энд оруулж байгаа төсвийн орлого хэсэг дээр асуулт асууя. Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн орлого дээр дараах доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ гээд Ерөнхий сайд, Сангийн сайд гээд гаргасан байгаа. Тэгэхээр энэ маань гүйцэлдэхгүй байвал орлого нь яг бүтнээрээ төвлөрөхгүй байх тохиолдолд юу болох билээ. Ямар хариуцлага байх вэ? Ер нь тийм төвлөрнө гэж үзэж байна уу?

**С.Ганбаатар:** Микрофон 8.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Уянга гишүүний асуултад хариулъя. Үндэсний баялгийн сангийн хуулийг бол бид анх удаа энэ анхдагч хууль байдлаар бол энэ удаа оруулж ирж байгаа. Шалтгаан нь бол Үндэсний баялгийн сангийн тухай хууль

бол энэ оны 4 сард бол батлагдсан. Энэ батлагдсантай холбоотойгоор бол 3 сантай, дотроо 3 сантай үндэсний баялгийн сан байна гэхчхэн байгаа. Энэ сангуудад хуваарилах хөрөнгийг бол энэ хууль дээр зохицуулахаар оруулж ирсэн байгаа.

Тэгэхээр бол доторх 3 сангаас бол бид нар хуримтлалын сан болон дээрээс нь ирээдүйн өв сантай холбоотой зохицуулалт энэ дээр орж ирж байгаа. Одоогийн Төсвийн тухай хуулиар ямар зохицуулалт явдаг вэ гэхлээр тооцооллын хувьд бол хэрвээ энэ тооцоолол нь буруу тоонд нь үндэслэгдсэн байх юм бол тухайн тооцооллыг хийсэн хүнтэй албан тушаалтанд нь бол ажлаас халахаар үндэслэл болно гэдэг л заалт байгаа. Тэр нь өөрөөр хэлбэл энэ тооцооллыг бид нар хийсэн хүмүүсийн хувьд нөгөө талдаа энэ тооцооллын дагуу орлого орохгүй байвал яах вэ гэдэг асуудал гарч ирнэ. Энэ нь бол Үндэсний баялгийн сан дээр заачихсан байгаа. Жишээ нь энэ 499 тэрбум төгрөгийн орлогыг бол нөгөө талдаа Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль дээр та харах юм бол 4 дүгээр зүйл дээр төсвийн ерөнхийлөн захирагчдын энэ тухайн санд төвлөрүүлэх орлого гэсэн байдлаар бол энийг бол ингээд заасан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл тухайн төсвийн ерөнхийлөн захирагчид нь энийгээ бас оруулах ийм үүрэг хүлээнэ гэсэн ийм агуулга орж ирж байгаа гэсэн үг.

Тэгэхээр бол нэг талдаа бол орлогоо төвлөрүүлэх нь хуульчлаад Монгол Улсын хууль болоод баталчихсан. Тэгэхээр тухайн хариуцаж байгаа этгээд энийг оруулах ёстой. Нөгөө талдаа бол энийг төлөвлөж байгаа этгээд буюу Сангийн яаман дээр энийг Засгийн газраас төлөөлж оруулах учиртай. Бодит тоон дээр буюу биелэгдэшгүй тийм тоо бол оруулж ирж болохгүй гэдэг ийм заалт байгаа.

**С.Ганбаатар:** Асуулт асууж хариулт авлаа.

Би нэг товчхон асуулт асуучихъя. Хэлэлцэх эсэхийн үед би энийг асуусан учраас энэ 2 дугаар хэлэлцүүлгийн үед бас би Аж үйлдвэржилтийн байнгын хороотой холбоотой асуудал гэж бодож асууж байна. Тэр үед олигтой хариултаа аваагүй. Ер нь уурхайн баялгаас орж ирж байгаа энэ орлогоос Ирээдүй өв санд 3.4 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй гэж байгаа. Тогтворжуулалтын сан 1.3 их наядын үлдэгдэлтэй гэж байгаа. Энэ яг мөнгөөрөө байгаа юу бичилт хийчихсэн байгаа юу? Миний асуулт нэг. 8 дугаар микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Энэ жил бол Сангийн сайдын тушаалаар бол яг энэ хуримтлагдсан энэ мөнгийг бол тусгайлан одоо бол нөгөө таны нөгөө өмнө асуугаад байдаг агуулгаар бол Төрийн сангийн нэгдсэн данс дотор байгаад байгаа зүйлийг тусгаарлаад тусад нь данс гаргаад Монголбанканд байршуулахаар бол тушаал гарсан. Энэ нь бол Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Үндэсний баялгийн сангийн тухай хууль дээр юу гээд заачихсан гэхлээр Монголбанканд дахь дансанд байршуулна гээд бүүр заачихсан хуулийн заалт байгаад байгаа юм. Тэр дагуу нь тушаал гаргаад бид нар бол тусгаарлаад эхэлж байгаа. Одоогийн байдлаар бол яг тусгаарлачихсан байгаа дүн нь би хэрвээ андуураагүй бол 1.7 их наяд орчим төгрөгийг ирээдүйн өв сангийнхыг тусгаарлачихсан байгаа. 3.4 их наяд гэдэг маань бол энэ оны эцэст гэхэд хуримтлагдаад очих мөнгө. Тэгэхээр өөрөөр хэлбэл он дуусахад бол бид нар тэр хэмжээнд Монголбанканд дээр яг мөнгөөр нь тусгаарлана. Сангийн сайдын тушаал дээр бол энийг тусгаарлахдаа америк



доллаароор тусгаарла гэдэг тийм агуулга орчхоод байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл Монгол Улсын валютын нөөц энэ тэр ч хэрэгтэй гэдэг агуулгаар нөөц дээр бол тусгаарлаад ингээд явж байгаа. Тогтворжуулалтын сангийн хувьд бол манай төрийн сангийн нэгдсэн данс дотор бол явж байгаа. Монголбанкн дээр бол тусгаарлаагүй ийм юутай байж байгаа.

**С.Ганбаатар:** Протоколд бичүүлж авлаа. Ингээд хариултаа авчихлаа.

Одоо гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт явуулж эхэлнэ.

Санал хураалт явуулж эхлэхийн өмнө Улсын Их Хурлаар энэ ярьж байгаа зүйлүүдийг бүгдийг нь та нарт мэдээлэл өгсөн учраас энэ дээр санал гаргах гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байгаа юу? Байхгүй байна.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар ингээд санал хураалт явуулъя.

Санал хураалт явуулж дууслаа. Энэ чинь зүгээр саналыг нь аваад хэлэлцүүлж байгаа юм байна шүү дээ. Хэлэлцүүлж байгаа юм байна. Санал гараагүй юм байна.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа танилцуулчих уу? Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Хуралдаан даргалагчийн хувиар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай

хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

16.40 цагт

Дараагийн асуудал. Монгол Улсын 2024 онд Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлэг хийнэ.

Монгол Улсын 2024 онд төсвийн тодотголын ажлын хэсэг хэвээрээ байгаа юм байна шүү. Ингээд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт орж, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдаж, зарим яамдын нэр Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудалд нь өөрчлөлт орсон цацраг идэвхт ашигт малтмалын болон цөмийн энерги ашиглах асуудал Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудалд шилжсэн тул Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт орж байгаа хуулийн төслийг та бүхэнд тараасан болно оо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйр зүйл бүрээр хэлэлцье.

Ингээд Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулт асуух гишүүд алга байна. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүн байна уу? Санал гаргах гишүүн бий юу? Санал гаргах гишүүн алга байна. Энэ нэр томъёоны асуудал юм байна лээ. Цөмийн тухай хуульд Цөмийн энергийн



тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Энэ урьд нь тараагдаад, чуулганаар хэлэлцэх эсэх асуудал нь шийдэгдээд хэлэлцчихсэн учраас энэ Байнгын хороодуудаар шууд ингээд асуудлуудаа яриад явж байгаа юм байна.

Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүн алга байна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна уу?

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хэлэлцэж санал авахгүй байгаа нь бүгдээрээ хэлэлцэж байгаа юм байна шүү. Ингээд Аж үйлдвэрлэгчдийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Гишүүддээ баярлалаа.

16.44 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДА  
ГМАА